

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

## 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООДЫН ХАМТАРСАН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 61

1. *Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан /үргэлжилнэ/*

5 – 61

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороодын  
3 дугаар сарын 25-ны өдөр /Мягмар гараг/-ийн хамтарсан  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих 49 гишүүнээс 27 гишүүн хүрэлцэн ирж, 55.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 31 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баярбаатар, М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Х.Баттулга, Э.Батшугар, Л.Гантөмөр, Д.Энхтүвшин;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Ж.Баярмаа, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Н.Номтойбаяр, Л.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан;

Тасалсан: Б.Жаргалан.

**Нэг.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан /ургэлжилнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтuya, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууниям, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, мөн газрын ахлах референт Д.Отгон, Д.Цэцэгмаа, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн

Э.Райымбек, мөн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Г.Оюунцэцэг, мөн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын мэргэжилтэн Ж.Өнөржаргал, Б.Төгөлдөр, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлнийцлийн аудитын газрын аудитын менежер Х.Баярмаа, Б.Сандуйжав, мөн газрын ахлах аудитор М.Наранжаргал, Г.Саранггоо, Н.Хандмаа, Б.Буянхишиг, М.Баяртогтох, Н.Уртнасан, С.Оюун-Эрдэнэ, Ж.Чинбат, А.Мөнхбадрал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга У.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, Үнэлгээ, мониторингийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Үнэлгээ, мониторингийн газрын зөвлөх Б.Отгонсүрэн нар байлцав.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, О.Номинчимэг, Л.Мөнхцэцэг, П.Батчимэг, С.Цэнгүүн, М.Мандхай, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Боловсролын сайд П.Наранбаяр, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Батбаатар, Э.Болормаа, Р.Батболд, О.Алтангэрэл, Б.Мөнхсоёл, С.Бямбацогт, Г.Уянгахишиг, Ц.Сандаг-Очир, Ө.Шижир, М.Мандхай, Б.Пүрэвдорж, Ж.Бат-Эрдэнэ нар уг хэлэв.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэл болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хамтарсан хуралдаан 2 цаг 21 минут үргэлжилж, 49 гишүүнээс 33 гишүүн хүрэлийн ирж, 67.3 хувийн ирцтэйгээр 15 цаг 52 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Р.СЭДДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 3 дугаар сарын 25-ны өдөр, Мягмар гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
13 цаг 31 минут

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Бат-Эрдэнэ:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117.3-д Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн тухайн жилийн гүйцэтгэлийн явцтай нэгтгэн гаргасан тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.2-т заасны дагуу хэлэлцэнэ гэж заасан байгаа. Энэ дагуу хуралдаан хэлэлцэж байна.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны хөгжлийн гүйцэтгэлийн тайланг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл ажлын 3 хоногийн завсарлага авсан.

Уг хуралдааны завсарлагын хугацаа дууссан. Хугацаа дууссан. /алх цохив/

Завсарганы хугацаа дууссантай холбогдуулан уг хэлэх үү? Хэлэхгүй юу.

Үргэлжилж байгаа асуудал шүү дээ. Тийм. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг үргэлжлүүлэн хэлэлцье.

---

**Нэг. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,  
Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны  
хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн  
2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан**

---

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 117.8-д Засгийн газар энэ хуулийн 117.1, 117.5-д заасан тайлан шинжилгээ хийж, 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хурлын гишүүдэд тараана гэж заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас тус бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, дүгнэлт хийж Та бүхэнд хүргүүлсэн болно.

Би хуулийг танилцуулъя. 117.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн тухайн жилийн гүйцэтгэлийн явцтай нэгтгэн гаргасан тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.2-т заасны дагуу хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлын хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлттэйгээр хүргүүлнэ гэсэн байна.

2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан болон гүйцэтгэлийн үр дүнд хийсэн аудитын тайланг тус тус танилцуулсан.

Тайлантай холбогдуулан гишүүд асуулт асуух, хариулт авах үргэлжилнэ.

Ажлын хэсгийг оруулчих. Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал сайд ирсэн байна. Эрдэнэбилэгийн Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Оюунсайханы Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сандагийн Бямбацогт Батлан хамгаалахын сайд, Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Ү.Амарбат Улсын Их Хурлын Тамгын газрын Дэд дарга, Б.Алтантуяа Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ,

мониторингийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Д.Эрдэнэсамбуу Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга, Б.Отгонсүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын зөвлөх, Х.Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Н.Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Жавхланбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Д.Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Э.Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Х.Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Батболд Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, А.Даваадорж Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Төмөрхүү Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, П.Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Х.Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ш.Мөнхцэцэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Ч.Өнөрбаяр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Д.Үүрийнтуяа Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга, Д.Отгон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын ахлах референт, Д.Цэцэгмаа Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын ахлах референт, М.Баярмаа Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын ахлах референт, Д.Наранцэцэг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын ахлах шинжээч, Д.Тэгшжаргал Гадаад харилцааны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал, Г.Бямбасүрэн Гадаад харилцааны яамны Бодлогын газрын захирал, Ц.Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Х.Оюунцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн ахлах шинжээч, З.Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, Г.Оюунцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн, Б.Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжилгээ, үнэлгээний газрын мэргэжилтэн.

Үндэсний аудитын газраас ирсэн ажлын хэсэгт оролцож байгаа хүмүүсийг танилцуульяа.

Д.Загджав Монгол Улсын өрөнхий аудитор, Я.Самбууныам Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Б.Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Х.Баярмаа Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, М.Наранжаргал Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Г.Сарангоо Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, Н.Хандмаа Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, Б.Буянхишиг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, М.Баяртготох Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор, Н.Уртнасан Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор.

Ингээд асуулт хариулт үргэлжилнэ. Г.Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Өдрийн мэнд хүргэе.

5 жилийн чиглэл, 4 жилийн хөтөлбөр, 1 жилийн төлөвлөгөөнүүдийн тайланг харлаа. Их сэтгэл хангалиун бус байна.

Өнгөрсөн намрын чуулганаар төлөвлөгөө, хөтөлбөрүүдийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт буюу Кэй Пи Ай нь үүнийгээ зөв тодорхойлох ёстай. Өчнөөн хэлсэн. Гүйцэтгэл дээрээ, тайлан дээрээ үүнийг засаж оруулж ир гээд саналаа хэлээд яамдуудад, Байнгын хороонд, нэгдсэн чуулганаар бүгдэд нь хэлсэн. Бахь байдгаараа ямар ч засваргүй орж ирсэн. Энэ хандлагаа хэзээ засах юм? Өмнө нь бол би дандаа зүгээр тайлбарлаж эвлэгхэнээр хэлсэн шүү дээ. Сайд нар Төрийн нарийн бичгийн дарга нар засна гэж хэлсэн. Нэг нь ч засагдаагүй. Алдаатай хэвээрээ байгаад байгаа юм. Хоорондоо зөрүүтэй, алдаатай, хийж байгаа ажлаа зөв хэмжих боломжгүй зүйлүүд тавьчхаад биелэлтээ 100 хувь гэж орж ирээд байгаа юм.

2020 оны Засгийн газрын 206 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам гэж баталсан. Түүний 6.2-т заасан аргачлал нь байгаа. Түүнийгээ баримталгүйгээр хяналт, үнэлгээ хийсэн байна. Үүнийг яагаад ингэж хийсэн юм? Яагаад баталсан журмаа өөрсдөө мөрдөхгүй байгаа юм? Хоёрдугаар асуулт.

Гуравдугаар асуулт. Жишээ дурдъя.

2024 оны жилийн төлөвлөгөөний үр дүнгээс Хавсралт 2.

2.3.1.эрчим хүчний салбарыг эдийн засгийн үр ашигтай болгоно.

Биелэлт 100 хувь.

100 хувь биелчихсэн юм уу? Энэ асуудал. Цахилгааны үнэ нэмээд иргэдэд, тэр дундаа утааг бууруулахад хувь нэмрээ оруулж байгаа, байшингага дулаалаад, цахилгаан халаагуур тавьсан айлуудын нуруун дээр маш том ачаалал үүсгэхчээд түүнийгээ үр дүнтэй ажилласан гээд биелэлтээ 100 хувь гэж тавьж байгаа харагдаад байна.

Алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит компаниудын засаглалыг хэмжсэн шалгуур үзүүлэлт ч юм уу, тийм зүйлээр энэ ажлын биелэлтээ хэмжиж болдоггүй юм уу?

#### 7.1.1.авлигын гэмт хэргийг бууруулна.

Биелэлт бас 100 хувь.

Манай улсын авлигын индекс чинь 2019 онд 35 оноотой байж байгаад сүүлийн 3 жил 33 оноотой. Ерөөсөө сайжраагүй.

Авлига албан тушаалын гэмт хэргийн тоо 2021 онд 335, 2022 онд 475, 2023 онд 569, өнгөрсөн жил 577 болж өссөн шүү дээ.

Тэгснээ биелэлтийгээ 100 хувь биелсэн байна гээд ороод ирж байгаа ийм логикийн алдаатай шалгуур үзүүлэлтүүдийг засахгүй юм уу? Хийж байгаа ажлынхаа үр дүнг бодитоор тайлагнадаг хэзээ болох юм бэ?

Гуравдугаарт нь, Хавсралт 3.7 дээр засаглалын үзүүлэлтийг сайжруулна гэсэн зорилт тавьсан боловч Дэлхийн банкны үнэлгээ гарцаагүй болохоор үр дүнг хянах боломжгүй гэсэн байгаа юм.

Энэ үнэлгээний аргачлал нь нийтэд нээлттэй байдаг. Үүнийгээ ашиглаад үнэлээд ороод ирж болдоггүй юм уу гэсэн ийм гурван асуулт.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэн хариулах вэ? Хэнээс асуусан бэ? Н.Учрал сайд хариулах уу? Тэгээд зохих хүмүүсээс нэмэлт хариулт авья.

**Н.Учрал:** Нэг жилийн төлөвлөгөөг Засгийн газар баталсан. Түүнийхээ хүрээнд 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрүүд дээр үнэлгээ хийгээд явж байгаа.

Хяналт хэрэгжүүлэх хуулиараа мэдээж Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагууд үнэлгээний аргачлалынхаа дагуу үнэлснийх нь дараа түүн дээр нь хяналт хэрэгжүүлэх газраас үнэлгээ өгдөг.

Тэгэхээр мэдээж төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн захиргааны байгууллагууд Засгийн газраас баталсан тэр үнэлгээний

аргачлалынх нь дагуу яг индикаторууд дээр нь үнэлгээ хийж байгаа гэсэн үг. Ингээд хяналт хэрэгжүүлэх газар үнэлгээ хийгээд эцэслээд энд орж ирж байгаа юм.

Тэгэхээр бид таны хэлж байгаа, хэрвээ зарим нь 100, 90 гээд хэрвээ дүгнэсэн байвал энэ бол жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тэр зорилтуудыг хангасан байдал болохоос биш тэр ажлыг эцсийн үр дүнд хүргэчихсэн гэсэн үг биш.

Анх тэр зорилтуудыг тэр төлөвлөгөөн дээрээ тусгахдаа энэ ажил магадгүй юу гэдэг юм техник, эдийн засгийн үндэслэлийг нь зарлаад ажил эхлүүлнэ гээд заачихсан бол тэрийг 100 хувь гэж үнэлж байгаа болохоос биш ажил дууссаны нэр биш.

Тийм учраас анхнаасаа тавьж байгаа тэр индикаторууд дээр нь ямар зорилтот түвшинд хүрэх ёстой юм. Тэр зорилтот түвшнийг хангасан байдлаар нь жил жилээр үнэлээд явж байгаа болохоос биш тэр барилга, байшин байгууллагаад, тэр цэцэрлэг ашиглалтад орсон тэр зорилтот түвшинд хүрсэн гэсэн үг огт биш.

Тэгэхээр хэрвээ энэ 100 хувь, 90 хувь гээд үнэлэгдээд байгаа бол тэр зорилтот түвшнийг хүрсэн эсэх дээр үнэлгээ хийж байгаа гэж ойлгож болно.

Ингээд одоо надад Засгийн газрын гишүүдийн хэрэглэж байгаа энэ DASHBOARD дээр харагдаж байна л даа. Жишээ нь, аймгууд яг энэ зорилтот түвшнээ хэр үнэлүүлсэн бэ гэдэг нийт үнэлгээнүүд нь тавигдаад, яам яамдаар зорилтот түвшнээ биелүүлснээр нь тухайлсан үнэлгээнүүдийг ингээд оруулчихсан байгаа.

2024 оны эхний хагаст 52 байгууллагын 124 ажлаас нийт үнэлсэн ажил дээр 2023 оны эхний хагаст үнэлэгдсэн ажлаас даруй 18 хувиар өндөр үнэлгээ авсан буюу зорилтот түвшинд хүрсэн гэдэг ийм жишээ нь дүгнэлтүүд гээд энэ гаргачихсан байгаа.

Тэгэхээр бид эх өгөгдөл дээр суурилсан шийдвэр гаргах чиглэлээр ямар ч байсан үнэлгээнүүдийг REAL TIME-аар цаг тутамд нь хараад үнэлгээ хийгээд явж байгаа.

Таны түрүүн хэлсэн тэр авлигын төсөөллийн индекс дээр өөрчлөлт, эерэг нөлөө үзүүлэх чиглэлээр тэр TRANSPARENCY INTERNATIONAL байгууллагатай ажилласан. Өнгөрсөн хугацаанд бидэнд тавьж байгаа шаардлага бол хэд хэдэн хууль тогтоомжийг өөрчлөх ёстой. Түүнээс биш богино хугацааны үйл ажиллагаанууд дээр биш.

Тэгэхээр яг үүнийхээ хүрээнд төрийн өмчийн компанийн засаглал сайжруулах чиглэлээр хаврын чуулганаар төрийн өмчийн компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль батлагдана. Ингэснээр авлигын индекс мэдээж маш том эерэг нөлөө үзүүлнэ.

Мөн Олборлох салбарын ил тод байдлын хууль буюу “Нээлттэй засгийн түншлэл”-д нэгдсэн улсын хувьд олборлох салбарын ил тод байдал, нэмээд Байгалийн нөөцийн ил тод байдлын хуулийг батал гэдэг ийм шаардлагыг өгсөн.

Байгалийн нөөцийн ил тод байдлын хууль, Төрийн өмчийн компанийн хуулийг Их Хурал энэ хаврын чуулганаар баталсны дараа авлигын индексэд томоохон өөрчлөлт авчирна.

Өмнө нь ч гэсэн авлигын индекс урагшлахад Засгийн газрын нээлттэй, ил тод байдал дээр үнэлгээ өгч байсан.

Түүн шиг бид олон улсад хүлээсэн үүргүүдээ биелүүлээд хууль тогтоомжуудаа боловсруулаад Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа. Тэгээд үүнийг баталсны дараа өөрчлөлт өгнө гэж хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Э.Одбаяр сайд. Нөгөөдөх нь хэн гэнэ ээ? Эрчим хүчний яам, Авлигатай тэмцэх газар уу? Авлигатай тэмцэх газар гэсэн үү?

Зорилт, шалгуур үзүүлэлтүүд нийцэхгүй байна гэсэн ийм асуулт байна шүү. 7 номер.

Ер нь Н.Учрал сайд аа, энэ ажлын хэсгээ ер нь цомхон болгох хэрэгтэй байна. 30, 40 хүн л орж ирээд байх юм. Хариулж байгаа хүн нэг ч байхгүй. Нэгэнт л ажил хариуцаж байгаа юм бол Засгийн газрын эрх бүхий хүмүүс өөрсдөө ажлаа мэдэх хэрэгтэй шүү дээ. Баахан хүмүүсийг яагаад л, цаашаагаа эргэж хараад л асуугаад суугаад байдаг.

7 номер.

**Ч.Өнөрбаяр:** Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Н.Учрал сайдын хариулт дээр нэмж хариулахад нэгдүгээрт манай Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар тайланг 1 сард үнэлсэн. Үнэлэхдээ энэ хуулийн хугацаатай. 4 сарын 01 гэхэд Улсын Их Хурал дээр хэлэлцэх ёстой байдаг. Түүнээс 45 хоногийн өмнө Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлдэг хуультай. Тэгэхээр 2 сарын 01 болчож байгаа юм.

Тэгээд 2 сарын 01-нд энэ таны асуугаад байгаа, Г.Лувсанжамц гишүүний асуугаад байгаа зарим шалгуур үзүүлэлтүүд гараагүй байдаг. Дэлхийн банкны зарим шалгуур үзүүлэлт, олон улсын авлигын индекс гээд.

Мөн Засгийн газрын үнэлдэг 206 дугаар журам сум дээр байгаа суурь шалгуур үзүүлэлтүүд нь зарим нь 2 жил тутамд гардаг. Ингээд үнэлгээ нь хийгдээгүй, олон улсын шалгуур үзүүлэлт нь гаргаагүй учраас энэ өөрөө 2 сарын 01-ний дотор гэдэг хуулийн хугацаандаа шахагдаад үнэлэх бололцоогүй байгаа юм.

Тэгэхээр цаашдаа ер нь энэ цаглаврын асуудлуудыг бас бүх түвшиндээ анхаарахгүй бол жишээлбэл Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль дээр 5 жил тутам үнэлнэ гэчихсэн байж байдаг. Өөрөөр хэлбэл урт хугацааны бодлогын баримт бичиг. Гэтэл Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль дээр 10 жил ч гэдэг юм уу ингээд зөрүүтэй зүйлүүд маш их байгаа юм гэдгийг хэлье.

Ер нь цаашдаа энэ асуудлыг цогцоор нь, тогтолцоогоор нь өөрчлөхгүй бол иймэрхүү хүндрэл дараа жил ч гэсэн бас гарахаар байгаа. Энэ бол цэвэр хуулийн зөрчилдөөний асуудал, хуулийн хугацааны зөрчилдөөний асуудал.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хуульд өөрчлөлт оруул. Г.Лувсанжамц гишүүн өөрөө буруутай болж байгаа юм байна шүү. Хууль чинь буруу байгаа юм байна.

Э.Одбаяр сайд.

**Э.Одбаяр:** Г.Лувсанжамц гишүүнд баярлалаа. Тэгээд ажил хэрэгч асуулт.

Ер нь бид яриад байгаа. Тэгээд та асуудлыг их зөвөөр харсан байна. Одоо энэ хяналтын чиг үүрэг дээр ч гэсэн анзаараад харахад З газрын тайлан орж ирж байгаа.

Ер нь Монгол Улсад төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт гэдэг асуудал учраа олохгүй явсаар байгаад өнөөдрийг хүрчихсэн байгаа. Тэгээд бидний хэлэлцэж байгаа энэ тайлан дээр яах вэ гэхээр цаг хугацааны хувьд жоохон давчуу байсан. Тэгээд Засгийн газраас анхаараад, Ерөнхий сайдын албан даалгаврууд дээр тусгагдаад явж байгаа. Бид хяналт үнэлгээний цогц системийг үйл ажиллагаандaa нэвтрүүлэх ёстой гээд ажиллаж байгаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон байгаа.

Тэгээд яг гүйцэтгэлийн хувьд олон яамдын, олон сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх дүрэм журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах. Тэгээд шаардлагатай бол Их Хуралд бас асуудлаа танилцуулах чиглэлээр ажиллаж байгаа. Тэгээд энэ ажлынхаа явцыг би танд дэлгэрэнгүй танилцуулна гэдгээ хэлэх гэсэн юм.

Ер нь шалгуур үзүүлтээ үйл ажиллагаа төлөвлөж байгаа субъект өөрөө гаргаад, өөрөө тайлагнадаг, өөрөө тайлангаа илгээдэг. Ерөөсөө өөрөө өөрийгөө үнэлдэг систем рүү л энэ өөрөө орчоод байгаа юм.

Тэгэхээр уг зүй нь бол яах вэ гэхээр төлөвлөлт, хяналт хоёр тусдаа явах ёстай. Тэгээд үнэлгээ илүү бодитой гарах ёстай гэдэг энэ зүг рүү хамтарсан Засгийн газар санал нэгтэйгээр алхаад явж байгаа.

Тэгээд явцынхаа тайланг танд эргээд нэг танилцуулна гэдгээ хэлэх гэсэн юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга. 2 дугаар микрофон.

**Н.Тавинбэх:** Эрчим хүчний яам. Төрийн нарийн бичгийн дарга. Г.Лувсанжамц гишүүний асуултад хариульяа.

Эрчим хүчний салбарын эдийн засгийн үр ашигтай болгох хөтөлбөрийн хүрээнд бид нэг л төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төсөвлөсөн.

Эрчим хүчний тарифыг индексжүүлж, зохистой түвшинд хүргэх гэдэг.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчинд Эрчим хүчний зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд эрчим хүчний үнэ, тарифыг индексжүүлэг арга хэмжээг авсан байгаа.

Тийм учраас бид биелэлтийг 100 хувь гэж гаргасан.

**Ж.Бат-Эрдэнэ:** Авлигатай тэмцэх газар. Ирээгүй байх аа. Ирээгүй байна.

Асуултаяа тодруулах юм уу? Г.Лувсанжамц гишүүн.

**Г.Лувсанжамц:** Н.Учрал сайд, Э.Одбаяр сайд, Н.Тайванбэх даргадаа, бас Ч.Өнөрбаяр даргад бас баярлалаа.

Яг харин та бүхний хэлж байгаа, ойлгоод байгаа зүйлийг л аль болох хурдан хийе гээд байгаа юм. Нэгэнт хэдүүлээ ингээд хамтарсан Засаг байгуулчихсан байгаа юм бол өөрийн хийсэн ажлаа өөрөө үнэлдгээ больчихоо. Гурвын гурван байгууллага ингэж олон орон тоотойгоор хянадгаа больчих ёё.

Үр дүнгээ зөв тавиад, хэмжээд, зорилт, шалгуур үзүүлэлт нь хоорондоо алдаатай байна гэсэн зүйлийг би асуулгаад байгаа шүү дээ.

Эрчим хүчний яаман дээр ч гэсэн, Авлигатай тэмцэх газар дээр ч гэсэн. Тэгээд хэмжих аргачлал дээр нь олон улсын байгууллагын тайлан гардаггүй гэдгийг нь өөрсдөө хийдэг болчож болдоггүй юм уу гэсэн асуулт байсан.

Тэгээд эцэст зарим биелсэн зорилтуудыг магтмаар байна л даа. Экспортыг нэмэгдүүлэх зорилт давуулж биелсэн. Цахим засаглал манайх 193 улсаас 46 улсад жагсаж байна. Энэ бол маш сайн үр дүн гэж харж байгаа. Үр дүндээ хүрч байгаа энэ байгууллагуудын төрийн албан хаагчдадаа баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Номинчимэг гишүүн. Ч.Өнөрбаяр хариулья. 7 номер.

**Ч.Өнөрбаяр:** Ер нь Засгийн газраас энэ үнэлэлтийг 2020 оны 260 дугаар журам бол бас жаахан хуучирчихсан.

Тэгээд Засгийн газар дээр бид үнэлгээ мониторингтой холбоотой 3 цогц журмыг батлуулчихсан. Тэгээд удахгүй албажаад, үүний дагуу юм хийгдээд явна.

Ер нь Засгийн газар дээр хийж байгаа ажил үр дүнтэй, төлөвлөдөг, төсөвлөдөг, гүйцэтгэлийг нь хянадаг энэ нэг цогц системийг бүрдүүлье гэдэг юм руу явж байгаа.

Тэгээд дараа жилээс энэ үнэлгээн дээр асуудлууд гарахгүй байх. Энэ дээр тодорхой шалгуур үзүүлэлт нь тодорхой болж байгаа. Дээрээс нь үүнийг ашиглаад Улсын Их Хурлын гишүүдээс хүсэлт байна. Энэ хуулиудын зөрчилдөөнтэй холбоотой асуудлуудыг шийдэхэд Та бүхэн маань дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байгаа. Яагаад гэхээр Монголд энэ хуулийн бодлогын зөрүү, хуулийн хугацааны зөрүү, ойлгомжгүй байдлаас болоод ингээд эзэнгүйдээд байгаа юмнууд бас байгаа. Үүнийг Г.Лувсанжамц гишүүнтэй урьд нь би ажлын хэсэг дээр уулзаж байгаад ярьж байсан.

Тэгэхээр ийм асуудлуудаас болоод хүндрэл үүсээд байгаа. Ер нь цаашдаа олон улсын шалгуур үзүүлэлийг маш тодорхой оруулах шаардлага байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэрвээ хуулийн хийдэл байгаад болохгүй байгаа бол Засгийн газар үүнийгээ өргөн барих үүрэгтэй шүү дээ. Энэ үүргээ хэдүүлээ мэдэж байх хэрэгтэй байна.

Яг амьдрал дээр яаж хэрэгжүүлээд, та нарт ямар хүндрэлд байгааг чинь бид мэдэхгүй шүү дээ. Тэрийгээ өргөн барих хэрэгтэй шүү. Ер нь бол. Хуулийн өөрчлөлтийг.

О.Номинчимэг гишүүн. Эрчим хүчний яам тодруулъя гэнэ. 2 номер.

**Н.Тавинбэх:** Эрчим хүчний зохицуулах хорооны үнэ тарифтай холбоотой гаргасан шийдвэр эдийн засгийн хувьд салбарт өгөөжөө өгч байгаа.

Тийм учраас би зөрсөн гэж үзэхгүй байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Номинчимэг гишүүн.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Энэ уг нь одоо юу шүү дээ. Улсын Их Хурал чинь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьдаг төрийн эрх барих дээд байгууллагын хувьд хамгийн том зэвсэг бол нэг нь төсөв. Тэгээд төсвийн гүйцэтгэлээ хянах. Нөгөөх нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг нь баталж өгөөд, түүний дагуу гарч байгаа нэг жилийн төлөвлөгөөнүүдийгээ бүгдийг нь батлах. Тийм ээ. Гүйцэтгэлийг нь хянах. Энэ хоёр л байгаа шүү дээ.

Тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлаад, үүний дагуу баталж байгаа энэ жилийн төлөвлөгөөгөө биелэлт нь ямар байна гэдэг дээр ярилцах гэхээр баахан үнэлгээ шалгуур үзүүлэлтийн асуудал гараад, үр дүнтэй өрөөсөө бид хоорондоо нэг шугамаар ярилцах боломжгүй болчоод байна л даа.

Тэгээд энэ гишүүдийн тавьж байгаа энэ шалгуур үзүүлэлтийн асуудал, үнэлгээний асуудал дээр хамаг гол учир нь байгаа гэдгийг хоёр талдаа хоёулаа бүгдээрээ ойлгоод байна. Тийм ээ. Ингээд баахан репорт үнэлгээ оруулж ирээд л, нүглийн нүдийг гурилаар хуурч байгаа юм шиг, бид нэг хэлэлцэж байгаа ч юм шиг, загнаад байгаа ч юм шиг, яаж байгаа ч юм шиг болоод хэлэлцэх бол уг нь үр дүнгүй л байгаа юм.

Тэгэхээр энд сая одоо энэ хэн Э.Одбаяр сайд, Ч.Өнөрбаяр дарга хоёр уг нь асуудлаа ойлгочихсон л байгаа юм байна шүү дээ. Тэгээд үүнийгээ хэзээ хийх вэ гэдэг чинь аягүй чухал байна.

Энэ уг нь үр дүнд суурилсан хяналт шинжилгээний үнэлгээ хийдэг байх энэ тогтолцоо чинь аль 2000-аад оны эхээр л Монгол Улсын төрийн үйл ажиллагаанд нэвтэрсэн шүү дээ. Яагаад одоо хүртэл яам, Тамгын газрын энэ арга хэмжээгээ төлөвлөх, түүн дээрээ шалгуур үзүүлэлтээ зөв тавих асуудал дээр хэрэгжихгүй байна гэдэг дээр Та бүхэн бас нэг дүгнэлт хийгээч ээ.

Саяхан хүртэл Улсын Их Хурлын Тамгын газар дээр ч гэсэн ажиллаж байхад шалгуур үзүүлэлт аягүй утгаа алдчихсан байсан. Жилд юу гэдэг юм 100 хууль батална. Өмнөх жил 100 хууль баталсан бол энэ жил 102 хууль батална гээд ороод ирдэг.

Энэ өрөөсөө ийм юмны шалгуур үзүүлэлт уг нь биш шүү дээ. Тийм ээ. Төрийн байгууллагад ирж байгаа иргэдийн өргөдөл, гомдол түрүү жил 700 байжээ. Энэ жил 600 болгоно ч гэдэг юм уу. Тийм ээ. Энэ яг юуг үзүүлэх гээд байгаа юм. Ерөөсөө чанарын үзүүлэлт ийшээгээ орж ирэхгүй ийм сонин арга хэмжээгээ бид төлөвлөөд байгаа гэдгээ яамд маань хараад, тэгээд үүнийгээ нэгтгэн харж, хянан шинжлэх үнэлгээ хийж байгаа газрууд маань бас анхаараад

энэ дээрээ хурдан үйл ажиллагаагаа хийгээд үр дүнгээ гаргаад өгөөч гэж хүсэж байна өрөнхийдөө.

Энэ үнэлгээн дээр гарч байгаа асуудал тэр цаг хугацааны асуудал дээр санал нэг байна.

Тэгэхээр энэ угаасаа Статистикийн хорооноос энэ чинь мэдээлэл хуулиараа аваад тэгээд 4 сарын 01 гэхэд байх ёстой гэхээр Үндэсний статистикийн хорооноос тоон мэдээлэл гарах хугацаатай зөрөөд байгаа. Үүнийгээ Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Тэгээд энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийг чинь гол зангидах хүн Эдийн засаг, хөгжлийн сайд, Шадар сайд маань байх ёстой. Энэ хүн тэгээд өөрчлөлтөө оруулаад ирэх ёстой шүү дээ. 6 сар боллоо. Юу хийж байгаа юм. Яагаад энэ явахгүй байгаа юм гэдэг асуудал байна.

Хоёрдугаарт, зарим асуудал.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Номинчимэг гишүүнд нэмэлт минут өгье.

**О.Номинчимэг:** Давхардсан учраас зүгээр тодруулж асуух юм.

Авлигын гэмт хэргийг бууруулна, авлигын үзүүлэлтийг сайжруулна гэдэг дээр Ч.Өнөрбаяр дарга энэ Transparency International-ийн индекс гарах болоогүй болохоор ч гэнэ үү. Нэг тийм юм ярчих шиг болох юм.

Энэ дээр Хууль зүйн сайд хэрвээ энэ үнэлгээгээ хийдэг бол яг өөрөө хариулаад өгөөч. Энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Тэгж байж авлигын индекс шалгуур үзүүлэлт нь байгаад, түрүү жил суурь юу нь 110 болсон. Тэгээд зорилт нь 109, үр дүн нь 108 байсан. Гүйцэтгэл 99 хувьтай гээд гарчихсан байгаа. Энэ яг авлигын индекс гэж альныг хэлээд байгаа юм? Миний мэдэж байгаагаар Transparency International дээр Монгол Улсын авлигын индекс сүүлийн 2, 3 жил 114 дээр байгаа. 110, 109 рүү орсон ерөөсөө байдал байхгүй.

Тэгэхээр Та бүхэн энэ авлигын индексийг энэ төлөвлөлтдөө оруулж ирэхдээ яг ямар индексээр тооцоод ахиц дэвшил гарсан гэж хараад байгаа юм бэ? Тэрийгээ тодорхой тайлбарлаж өгөөч? Танай үнэлгээг чинь хийдэг хүн бол өөр байр суурьтай. Тийм ээ. Өөр тоо мэдээлэлтэй явж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Алтангэрэл сайд.

**О.Алтангэрэл:** Авлигын индекс. Бид ер нь Transparency International-ийн тэр төсөөллийн индексийг ер нь ашигладаг.

Яг таны асуугаад байгаа асуудал дээр тавигдаж байгаа асуудлын хувьд уг нь Авлигатай тэмцэх газар бас энэ асуудлыг илүү сайн мэдэж байгаа байх.

Бид ямар асуудал тавьж байгаа вэ гэхээр ер нь авлигатай авлигын индекс бол цогц асуудал. Та сайн мэдэж байгаа. Жишээлбэл, энэ тайлан дээр авлигын гэмт хэргийн тоо 2020 оноос хойш тасралтгүй өссөн байна. 2020 оноос хойш тасралтгүй өссөн учраас бид энэ дээр үнэлгээг нь бага тавьж байна гэчихсэн байгаа. Гэтэл дахиад бид хэрвээ энд үнэлгээ гаргах гэж байгаа бол энэ авлигын гэмт хэрэг их байгаа, авлига их байгаа гэж байгаа энэ үед авлигын гэмт хэргийг мөрдөн шалгаж байгаа тоо нь ихэсвэл энэ өөрөө сөрөг үзүүлэлт болох ёстой юу, эерэг үзүүлэлт болох ёстой юу гэдгээс авхуулаад асуудлууд зэндөө байгаа юм.

Хууль зүй, дотоод хэргийн яамны хувьд Засгийн газрын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд Авлигын багц хуулийн төслийг боловсруулаад Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд одоо Улсын Их Хуралд өргөн барих гээд тов хүлээж байгаа. Энд бид Авлигын эсрэг хууль, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах болон нөхөн төлүүлэх тухай хууль гээд нийтдээ 10 орчим хуулийн өөрчлөлтийг Авлигын багц хууль болгож оруулж ирээд бид хүлээж байгаа. Ийм байдалтай байгаа.

Авлигын индексийн хувьд онооны асуудал ярьж байгаа. Түүнээс биш хамгийн суулийн гарсан индексээр Монгол улс 5 байр урагшилсан ийм үзүүлэлттэй байгаа санаж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Номинчимэг гишүүн тодруулъя.

**О.Номинчимэг:** Сайд нар Улсын Их Хуралд мэдээлэл өгөхдөө баримт нотолгоотой мэдээлэл өгөөч. 5 байр яаж урагшсан юм? Миний одоо яг интернэтээр харж байгаагаар Transparency International дээр Монгол бол 113. Өмнөх жилээсээ өрөөсөө урагшлаагүй. 114. 180 улсаас. Тэгээд өмнөх жилээсээ өрөөсөө урагшлаагүй 0 гэж гарсан байна.

Тэгээд бид яагаад Хууль зүйн сайд нь ингээд буруу өөр мэдээлэл өгөөд, Хяналт шалгалтын газрын дарга нь болохоор энэ авлигалийн индекс нь ийм өөр 110 биш 114 байхад үүгээр Transparency International-ээр явна гээд байгаа юм бэ? Үүнийгээ тодруулаач ээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Наадхыг чинь би мэдэхгүй. Авлигатай тэмцэх газар мэднэ гээд байгаа юм биш үү? О.Алтангэрэл сайд.

Ч.Өнөрбаяр дарга. 7 номер.

**Ч.Өнөрбаяр:** Нэгдүгээрт, энэ бол Авлигатай тэмцэх газар үнэлгээгээ гаргаад Хууль зүйн сайдад хүргүүлээд нэгтгээд ирдэг. Тэгээд Хууль зүйн сайд хариулт өгсөн.

Түрүүн би авлигын индекс гэж хэлээгүй. Ер нь зарим Дэлхийн банк ч гэдэг юм уу, бусад шалгуур үзүүлэлтүүдэд заасан суурь үзүүлэлтүүд гараагүй байдаг гэсэн хариултыг өгсөн.

Авлигын асуудал дээр ер нь ийм юм билээ. Анхнаасаа төлөвлөхдөө авлигын индекс 109-д орохоор төлөвлөчихсөн байсан юм билээ. Тэгээд энэ бас төлөвлөлтийн асуудал дээр цаашдаа анхаарах ёстой байх. Төлөвлөлтийг манай газар хийдэггүй. Зөвхөн тайлангаа unelgee.gov.mn байсан тохиолдолд бид хяналт шалгалт, үнэлгээ хийгээд баримт дээр суурилж үнэлгээг гаргадаг ийм журам зарчимтай. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ хичээл заагаад байдгийг яах юм бэ? Н.Учрал сайд аа. Гишүүд асуулт асуухаар дандаа тайлбар, тэгээд дандаа өөдөөс нь хичээл заагаад явчих юм.

Тэр зөрөөд байгаа асуудлыг ярьж байна шүү дээ. Наадах чинь. Яагаад зөрөөд байгаа юм гэдэг асуудлыг асууж байна шүү дээ. 1 номер.

**И.Батхүү:** О.Номинчимэг гишүүний асуусан түрүүн хөгжлийн бодлого төлөвлөлттэй холбоотой тогтолцооны сайжруулах асуудлуудыг яагаад өнгөрсөн хугацаанд хийгээгүй юм бэ гэдэг асуултад хариульяа.

Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаартай тушаалаар улсын жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж аргачлалыг баталсан. Энэ аргачлалын дагуу хамгийн эхэнд боловсруулж батлуулсан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө бол 2024 оных байгаа. Өнөөдөр хэрэгжиж байгаа, ярилцаж байгаа. Энэ бол бодлогын тэргүүлэх чиглэл, төсөл, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт гэсэн 3 үндсэн хавсралттай. Анх удаагаа ийм бүтэцтэй батлагдсан.

Бодлогын тэргүүлэх чиглэл дээр Эдийн засаг, хөгжлийн яамнаас салбаруудын болж бүтэхгүй байгаа асуудлуудыг засаж сайжруулах реформуудын асуудлуудыг их оруулж өгдөг. Хамгийн чухал гэж үзсэн асуудлуудаа. Энэ бодлогын тэргүүлэх чиглэлээ дэмжсэн төсөл, арга хэмжээнүүдийг дараагийн хавсралтдаа оруулаад явж байгаа юм.

Гуравт нь, дурдсан тэр төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг үнэхээр боловсруулж гаргаж ирэх, тодорхойлохдоо хүндрэл бэрхшээл байгаа. Яг хэрэгжүүлж байгаа яамд, агентлагууд өөрсдөө үүнийг боловсруулж гаргадаг.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Жаргалан гишүүн. Б.Жаргалан гишүүн байхгүй байна уу? Б.Пүрэвдорж гишүүн сүүлдэж орж ирээд битгий хурал үймүүлээд байгаарай.

М.Мандхай гишүүн.

**М.Мандхай:** Уучлаарай. Энд асуултаяа асуучихмаар байх юм. Минут яваад байх юм. Ямар хэцүү юм бэ? Нэг бол минутаа дахиад тэглэж байгаад шинээр эхэлье. Тэгэх үү?

**Ж.Бат-Эрдэнэ:** М.Мандхай гишүүний микрофоныг.

**М.Мандхай:** 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл дээр яг энэ хүнсний хангамж, аюулгүй байдалтай холбоотой их чухал чиглэл байгаа.

Энэ дээр аягүй ноцтой ийм дүгнэлт байна л даа. Үндэсний аудитын газраас.

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна гэсэн үндсэн чиглэл дотроо хүнсний аюулгүй байдлын индекс тооцох аргачлал байхгүйн улмаас дээрх үр дүнг тооцох, үнэлэх боломжгүй гэсэн асуудал ороод ирлээ. Энэ миний хувьд ноцтой асуудал харагдаж байна.

Яагаад энэ үндсэн үйл ажиллагааны чиглэлийн 5 дээр хүнсний аюулгүй байдлыг хангана гэдэг тэргүүлэх чиглэл өөрөө орчоод, тэгэхэд үндэсний аудит болохоор үүнийг ерөөсөө тооцох ямар ч индекс, аргачлал байхгүй гээд явж байна.

Тэгэхээр үндсэндээ бид хүнсний аюулгүй байдлын асуудлыг хэмжих ямар ч боломжгүй. Тэгвэл энэ тэргүүлэх чиглэл чинь өөрөө хэрэгжихгүй юм.

Уучлаарай би энд ярьж байна. Тэгэх үү? Та ямар хэцүү юм бэ? Сүүлд ч орж ирчхээд хүний яриа таслаад байх юм.

Хоёрдугаарт, авах арга хэмжээний хэрэгжилт 5.1.1.4 дээр НӨАТ-ын системд тулгуурлан хүнсний бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хянах, бүртгэх, дэмжлэгийг оновчтой болгох цахим системийг хөгжүүлэх гэсэн асуудал байгаад байгаа юм.

Тэгэхдээ яг бодит байдал дээр хүнсний боловсруулах үйлдвэрүүд л бүртгэгддэг байгаа. Энэ НӨАТ-ын системд. Малчид болохоор мал эмнэлгийн цахим системд “А” дансаараа бүрэн хангагдсан. Малаа зарах юм уу, эсвэл идэш хийхэд энэ мал эмнэлгийн цахим системээс хасалт хийгддэг. Гэхдээ яг бодит байдал дээр татварын системд мал худалдаалсан тоогоо сайн дураараа бүртгүүлдэггүй.

Тэгэхээр малчдаас малыг авч байгаа ченж нар татварын системд бас бүртгүүлдэггүй байгаа.

Тэгэхээр энэ ямар асуудал үүсээд байна вэ гэхээр зөвхөн урамшуулалд хамрагддаг сүүний үйлдвэр, тариаланч, гурилын үйлдвэр, махны үйлдвэрүүд хамрагддаг.

Тэгэхээр бусад үйлдвэрүүд бүрэн хамрагддаггүй учраас түүхий эдийн гарал үүсэл малчид, ногоочид татварын бүртгэлд хамрагдаагүйн улмаас өрөнд ордог асуудал, НӨАТ-ын өрөнд ордог асуудлыг үйлдвэрлэгчид удаа дараа тавьдаг.

Гэтэл энэ 5.1.1.4 дээр НӨАТ-ын систем дээр цахим системийг хөгжүүлэхэд 100 хувийн үр дүнтэй гэж гэж гарсан байна. Энэ зөвхөн цахим системээ бид босгоод ирчихсэн учраас үр дүн нь 100 хувь гэж үзэж байгаа юм уу? Эсвэл энэ өөрөө цахим систем.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** М.Мандхай гишүүнд дахиад нэмэлт минут өгье.

**М.Мандай:** Энд хамрагдаж байгаа бүх субъектүүдийг яг энэ НӨАТ-ын бүртгэлд оруулаад бид НӨАТ-ыг нь бүртгэж чадаж байгаа юм уу гэдэг асуудал.

Тэгэхээр энэ 100 хувийн үр дүн чинь ямар юмыг үнэлээд байгаа юм бэ гэдгийгээ нэг тодорхой хариулаад өгчихгүй юу.

Тэгээд дараагийн асуудал байна. Энэ хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна гэсэн чиглэл дээр хэрэгжиж байгаа “Цагаан алт”, “Шинэ хоршоо” хүнсний хангамж, аюулгүй байдлын 3 том үндэсний хөдөлгөөн байгаа. Энд 2 чухал төсөл хөтөлбөрийн хэрэгжилт 0-ээс 29 хувьтай явж байгаа. Нөгөө Эмээлтийн эко аж үйлдвэрийн парк, Дарханы арьс ширний үйлдвэрийн парк. Жишигэлбэл, Эмээлтийг 90 хувьтай гээд тавьчихсан байна л даа. Гэтэл 90 хувийн үнэлгээг чинь Тамгын газар үнэлэхдээ 50 хувьтай гээд явчихсан байгаа.

Яг өнөөдөр бодит байдал дээр арьс шир үйлдвэрлэж байгаа үйлдвэрлэгчид тэнд ямар ч дэд бүтэц байхгүй. Дэд бүтцийг нь шийдээгүй байхад бид орж тэнд үйл ажиллагаа явуулах.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Хөдөө аж ахуйн сайд байна уу? Хөдөө аж ахуйн Төрийн нарийн бичгийн дарга хариулах уу? Т.Жамбалцэрэн. Байхгүй юу? Сая дуудсан шүү дээ. Хэн хариулах юм бэ? Н.Учрал сайд хариулах уу? Яах юм. Хариулах хүн алга уу? Хөдөө аж ахуйн сайдыг дууддья. Хөдөө аж ахуйн Төрийн нарийн бичгийн даргыг дууддья.

Амархан ирдэг болоод тийшээ нүүсэн юм байгаа биз. Хөдөө аж ахуйнхныг дуудаарай. Энэ Эдийн засгийн хөгжлийн сайд хаачсан юм? Эдийн засгийн

асуудлаа томоор нь харж байх ёстой гэж Үндсэн хуульд ийм функц оруулсан шүү дээ.

Б.Мөнхсоёл гишүүн асууж байя.

**Б.Мөнхсоёл:** М.Мандхай гишүүний асуусан асуултад хариулах хүн байхгүй байна гэдэг нь түрүүний долоо хоногт энэ хурал болсон. Б.Баярбаатар гишүүний горимын саналаар энэ хурал долоо хоног хойшилсон шүү дээ. Тэгээд тэр үед Л.Гантөмөр сайд байхгүй байна. Сайд нар бас байх хэрэгтэй гээд хойшилсон. Одоо бүр дордчихсон юм шиг санагдаж байна. Гишүүд нь ч цөөрчхөж, сайд нар нь ч цөөрчхөж гэдэг шиг.

Хоёрдугаарт нь, хамгийн гол асуулт юу вэ гэхээр төдийгөөс өдийд. Түрүү долоо хоногт ч гэсэн Х.Ганхуяг гишүүнээс авхуулаад асуусан. Өнөөдөр ч гэсэн асуултууд үргэлжилж байна.

Бид нэг ийм жүжиг товлоод байгаа юм шиг. Нэг нь нэгнээсээ асуусан болж, нөгөөдөх нь хариулаад байгаа юм шиг буюу юу асууж, юу хариулаад байгаагаа үнэхээрийн координат, уялдаа холбоо байхгүй ийм байна.

Түрүүний хурлын асуултын дараа Тамгын газраас бас Засгий газрын Хэрэг эрхлэх газрынхан яаж үнэлгээгээ хийсэн бэ гэдэг тайлангаа явуулсан. 8 гол чиглэл байна гэж байгаа юм. Түүн дээр нэг гол асуудал бол “Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах” гээд 3 дугаар гол чиглэл. Тэр зоро буюу ноль хувьтай байна шүү дээ. Өөрөөр хэлэх юм бол хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах, түгжрэлийг сааруулах гэсэн энэ зорилтууд чинь тэг хувьтай байна гээд дүгнэхихсэн байна. Үүнийг жишээлбэл би үнэн гэж харж байна. Бусад субъектүүд хэрхэн үнэлсүүнийг гүйцэж харсангүй. Яагаад гэвэл координат гэдэг дээр би бид түрүүний хурлаар санал нэгдчихсэн.

Тэгэхээр үнэлгээний тайлантай холбогдуулаад бүр мянган асуулт асууж болж байна. Би зүгээр дохио өгөх үүднээс ганцхан.

Монгол Улс хөгжихийн тулд хүнээ дээдэлье, хүн төвтэй байя, хүндээ анхаарья, цементтээ багасгая энээ тэрээ гээд ная ярьсан, зөндөө ярьсан. Гэтэл үр дүн тэг байна гэдгийг анхаарах цаг нь болчихжээ буюу хоёрдугаарт дараагийн логик асуулт. Яах гэж үнэлээд байгаа юм бэ? Ер нь. Энэ үнэлгээ юуны төлөө хийж байгаа юм. Зорилго байх ёстой шүү дээ. Зорилгогүй нэг юм хийх ёстой. Хийчихсэн юм байна. Хийснээ танилцуулах ёстой гээд танилцуулж байгаа юм байна.

Гишүүд нэг юм асуумаар болно. Хариулах ёстой гээд ингээд сууж байгаа нь нэг бодлын маш их хайран бөгөөд жүжиглэлтийн шинжтэй санагдаад байна.

Бас нэг ноцтой мэдээ зүгээр хэлье. Яагаад би жүжиг гээд байна, яагаад бид өөрсдийгөө хуураад байна аа? Засаг ч тэр, Их Хурал ч тэр юу гэдэг юм бусад оролцоотой субъектүүд. Яагаад вэ гэхээр улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр 2022 оноос хойш орсон ажил, арга хэмжээ гээд байна шүү дээ. Тоонууд. Тэрийг харахаар жишээлбэл 2022 онд 20.1 хувьтай, 2023 онд 66 хувийн гүйцэтгэлтэй. Тэгснээ 2024 онд 38, тэгээд 2025 онд энэ юу гэнэ вэ. Дараагийн онд нь 29 хувьтай гээд яг нөгөө улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй улсын төсвийн бодлого нь нийцтэй байх ёстой гээд нөгөө хуулиараа заалт чинь бүр яагаад ч хэрэгжихгүй байгаа гэдгийг чинь Та нарын өөрсдийн гаргасан энэ тоо чинь батлаад байна.

Тэгэхээр одоо бүгдээрээ яах вэ? Яаж ийм хоёрын хооронд биш.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Асуултаа дуусгах уу? Хэнээс асуусан юм? Хэн хариулах юм? Э.Одбаяр сайд уу? Э.Одбаяр сайд.

**Э.Одбаяр:** Б.Мөнхсоёл гишүүний асуултад хариульяа.

Тэгээд түрүүн Г.Лувсанжамц гишүүний асуулттай бас зарим агуулга нь давхцаж байна.

Тэгээд жүжиглээд гээд. Үгүй яах вэ дээ, одоо тэгээд хэдүүлээ бүх юм бол бас сайхан байна гэж ерөөсөө үзэхгүй байгаа. Тэгээд өнөөдрийг хүртэл явж ирсэн, төлөвлөж ирсэн, тайлагнаж ирсэн, үнэлж ирсэн систем нь энэ.

Тэгээд одоо үүнийгээ хэдүүлээ өөрчилье гээд Засгийн газар дээр яриад Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, тэгээд миний бие энэ 4 хүнтэй ингээд ажлын хэсэг гараад ажиллаж байгаа юм.

Тэгээд түрүүний хариултыг давтаад хэлэхэд олон улсын үнэлгээний цогц системийг оруулж, аргачлал, тэр үнэлгээний аргачлалаа, шалтуур үзүүлэлтээ боловсронгуй болгоё гэдэг дээр ажиллаж байгаа. Тэгээд цаг хугацааны хувьд яг тодорхой одоогийн байдлаар үр дүн гарч чадаагүй байгаа дээр бид хүлээн зөвшөөрч байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Учрал сайд.

**Н.Учрал:** Ер нь Их Хурлаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын хууль гээд С.Бямбацогт сайд ахлаад энэ хууль батлагдаж байсан.

Энэ хууль батлагдсанаараа тогтолцооны хувьд бас их зөв болсон. Юу вэ гэхээр энэ 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, түүнд сууринсан хөгжлийн төлөвлөгөө. Үүнийг Эдийн засаг, хөгжлийн

яам өөрөө хариуцдаг. Тэгээд цаашлаад хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг нь эргээд үнэлдэг ийм зөв тогтолцоо руу орсноороо өнөөдөр Төрийн байгуулалт, Эдийн засгийн байнгын хороон дээр бид хамтдаа Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төлөвлөгөөний дагуу энэ нийцлийн аудитын тайланг сонсоод асуугаад сууж байна.

Тэгэхээр энэ өөрөө тогтолцооны маш зөв алхам байсан. Ингээд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хууль дээр тухайн үед дотоодын хяналт шалгалтыг хяналт хэрэгжүүлэх хуулиар зохицуулна гээд шинэ эрх зүйн орчин бүрдсэн. Тэгээд түүнийхээ дагуу бид ажиллаж байгаа.

Тэгээд одоо бол яг ийм бас шинэ гараанаас ирэх нөхцөл байдал мөн үү гэвэл мөн. Бид хаврын чуулганаар Нийтийн албаны хуулийг өргөн барина. Тэгээд цаашлаад Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн дээр ч гэсэн эргэж харахгүй бол тогтолцоо, системийн хувьд үл ойлголцлууд бий болчихсон гэвэл болчихсон.

Тийм учраас бид Нийтийн албаны хуулиар үүнийг бүхэлд нь шийдээд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хууль дээр эргэж харахгүй бол болохооргүй байгаа. Жишээ нь, хувийн байгууллагууд бүгдээрээ одоо Ки Пи Ай хэрэгжүүлдэг. Одоо KEY PERFORMANCE INDICATOR-уудаа тавьж байгаад түүнд нь үнэлдэг.

Түүнийгээ үнэлэхдээ манай төрийнхөн жишээ нь өөрсдийгөө үнэлээд, дээр нь хяналт хэрэгжүүлэх газар нь үнэлнэ гэдэг бол энэ зөв тогтолцоо мөн үү гэвэл мөн шүү дээ. Жишээ нь, хувийн байгууллагуудад бүгдээрээ л 360 градусаар өөрийгөө үнэлдэг. Дээд албан тушаалтан үнэлдэг. Доод албан тушаалтан үнэлдэг. Ингээд дундаж нь ямар вэ гэдэг дээр дүгнэлт гаргана. Яг үүнтэй адилхан төрийн захиргааны төв байгууллагууд ч бай, төрийн захиргааны байгууллагууд ч бай үнэлдэг үнэлгээний аргачлалыг нь Засгийн газар тавьж өгдөг. Жилийн төлөвлөгөөг биелүүлж байгаа дээр нь индикаторуудыг нь тавьж өгдөг. Индикаторууд нь хэмжигдэхүйц байдаг.

Тэгэхээр хэмжигдэхгүй том зорилтууд тавиад түүнд хүрнэ гэдэг бол бэрхшээлтэй байхгүй юу.

Тийм учраас хэмжигдэхүйц зорилт тавьсныг бид бас буруутгах гээд байх юм байхгүй юм билээ. Яагаад гэхээр өнөөдөр энд Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр чинь 4 жилийн дараа дүгнэгдэх болохоос биш жилийн дотор тэр сургуулийн барилга чинь баригдаад, цэцэрлэг баригдаад одоо энд өөрчлөлт шинэчлэл шууд орно гэж байхгүй шүү дээ.

Энэ бол жилийн төлөвлөгөө. Жилийн төлөвлөгөө чинь өөрөө зорилтот түвшиндээ хүрсэн байхыг л үнэлж байгаа учраас үнэхээр ТЭЗҮ боловсруулна гээд л зорилт байгаа бол тэр нь биелсэн бол 100 хувь гэж үнэлэхээс өөр энд

арга зам байхгүй шүү дээ. Түүнээс биш бид ингээд шууд утгаараар энэ 4 жилийн дараа хэрэгжих зорилтыг өнөөдөр шууд тэгж томьёолж бол болохгүй юм билээ.

Тийм учраас бид энэ хаврынхаа чуулганаар Нийтийн албаны хуулиа өргөн барья. Энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хууль маш зөв хууль. Тийм ч учраас Эдийн засгийн хөгжлийн яам байгуулагдсан. Тэгээд жил жилээр ажлаа тайлагнаад явъя. Цаашлаад бид ер нь анхан шатдаа ч тэр, дунд шатдаа ч тэр үнэлээд тэр нь өөрөө шударга байхгүй бол зөвхөн дээд тал нь үнэлдэг байх юм энэ чинь бас шударга биш шүү дээ.

Тэгэхээр аль аль түвшиндээ үнэлээд л дунджаар тооцдог, зорилтот түвшин нь бодитой ийм л байх нь зөв юм байна л гэж үзэж байгаа. Тэгээд одоо бид ч гэсэн үнэлгээ тэр GOV.MN дээр энэ бүх үнэлгээнүүд нэгдээд л яам өөрийгөө юу гэж үнэлсэн юм, хяналт хэрэгжүүлэх газар юу гэж дүгнэсэн юм гээд л энд би хараад л байж байна л даа.

Тэгэхээр ер нь ажил урагшилж байгаа. Анх удаа бид хөгжлийн бодлого, хөтөлбөрөө үнэлж байгаагаа л.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Мөнхсоёл гишүүн тодруулъя.

**Б.Мөнхсоёл:** Тодруулаад ганцхан юм асуучихъя.

Аргачлал дээрээ чанарын судалгаа хийдэг юм болов уу? Жишээлбэл, фокус группийн ярилцлагууд хийдэг юм болов уу гээд ганцхан юм асуучихъя.

Би ингээд хөндлөнгөөс харахад, түрүүний хурал, энэ хурлаас харахад алдаа дутагдал юун дээр байна вэ гэхээр координат, уялдаа холбоо алга. Үнэлгээ хийж байгаа бай байгууллагууд хоорондын, мэргэжилтнүүд хоорондын.

Хоёрдугаарт, чанарын асуудал байна. Мэдээж үүнийг сая ярилцчихлаа шүү дээ. О.Номинчимэг гишүүн ухраагүй гэхэд нөгөөдөх нь ухарсан. Дүнгээ ч гэсэн сайн танилцаагүй.

Тэгээд цаг хугацааны хомсдмол шинж байгаа юм болов уу?

Дөрөвдүгээрт нь, яагаад бид хүрэх үр дүндээ хүрч чадахгүй байна вэ гэхээр анхнаасаа энэ хүмүүс чинь ч гэсэн хэлээд байна шүү дээ. Төлөвлөхдөө бодитой төлөвлөж чадахгүй, тооцож чадахгүй байна. Хүрэхээргүй үр дүн тавьчихаар чинь хэрхэн үр дүнд хүрэх юм. Бараг зарим хүмүүс нь яаж, хэрхэн үр хүрэх вэ гэдгээ анализ хийж, нөхцөл байдлаа томьёолж байж бодит дэвшил, хүрэх үр дүн тавихгүй бол худлаа. Гэтэл тэрийгээ тавьсан зорилгоо ч мэдэхгүй хүн байгаад байна шүү дээ.

Тэгэхээр би бол.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** 1 номер уу? 1 номер.

**И.Батхүү:** Б.Мөнхсоёл гишүүний асуусан асуултад нэмэлт мэдээлэл өгье.

Сая улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн төсөл хооронд уялдаа холбоо муутай байгаа гэсэн энэ асуудлыг хөндсөн. Өмнөх жилүүдэд бол ийм асуудал байсан. 2022 оны төлөвлөгөөний хувьд дөнгөж 36 хувийн нийцэлтэй. 2023 оны хувьд 47, 2024 оны хувьд 71 хувийн нийцэлтэй. 2025 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсөв 92 хувийн нийцэлтэй болж байна.

Энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог төлөвлөлт талдаа бас сайжруулаад хичээж ажиллаж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** П.Батчимэг гишүүн.

**П.Батчимэг:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн хуралдаанаар уг нь энэ 3 цогц асуудал хөгжлийн бодлого бичиг баримт орж ирэх ёстой байсан. Азтай нь Ардчилсан намын бүлгийн дарга ажлын 3 хоногийн завсарлага авч асуудал хойшилсон байгаа.

Үнэхээр гишүүдэд унших, мэдэх, танилцах, материалыг үзэж судлах ийм хугацаа маш хомс байдагтай холбоотой энэ асуудлыг би хэлж байгаа юм.

Аудитын газрын тайлан жишээ нь дүгнэлт 3 сарын 13-ны өдөр энд бичигдэж ирсэн байхад бид нарын гар дээр дөнгөж тав дахь өдөр ирж байх жишээтэй. Өглөө.

Тэгэхээр Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын тайлан. Тэрийг уншиж судлах хэрэгтэй болчихсон. Аудитын тайлантай танилцах, Засгийн газрын өөртөө өгсөн тайлан гээд. Энэ олон тайлан, санал, дүгнэлтүүдийг уншихад бас тодорхой хугацаа ордог юм.

Аудитын газар энэ дүгнэлт дээр ингэсэн байгаа юм. Тайлан дээр. Энэ их анхаарал татлаа л даа.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу иж бүрэн, судалгаа тооцоотой боловсруулаагүйгээс төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй, гүйцэтгэлийг бодитой үнэлэхэд хүндрэл учруулж, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжилд үзүүлэх үр нөлөөг бууруулж байна гэсэн ийм дүгнэлт өгчихсөн байгаа юм.

Тэгэхээр дүгнэлт өгсөн аудитын газрын хүмүүс, дарга энэ дээр ямар дүгнэлт, яагаад ийм дүгнэлт гаргах болов гэдгийг нь хэлж өгөөч. Эсвэл хууль тогтоогч, үндсэн чиглэлийг баталсан Улсын Их Хурлаа буруутгах гээд байгаа юм уу, эсвэл Засгийн газартаа тал засах гээд байна уу? Энэ маш гайхал төрүүлсэн дүгнэлт боллоо гэж би харсан.

Тэгээд хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийн төсөл, хөтөлбөр нийтдээ 65 байгаа. Үүнийг Их Хурал үр дүнгүй, 0-ээс 29 гэсэн ийм оноо өгчихсөн байгаа юм. Ингээд дүгнэчихсэн байгаа юм.

Яагаад үүнийг үр дүнгүй ийм төсөл, хөтөлбөр гээд дүгнэчихсэн юм бол оо. Энэ тэргүүлэх үндсэн чиглэл дотор чинь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх. Тийм ээ. Экспортыг нэмэгдүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах гээд маш олон гол гол ажлуудыг тусгачихсан байтал энэ үзүүлэлтүүд бүгдээрээ “тэг” гэсэн үнэлгээтэй гарчихсан. Үнэхээр энэ дээр бүр сэтгэл дундуур байна.

Тэгэхээр Засгийн газар ер нь өнөөдөр ажлаа хийж байгаа юм уу, үгүй юу гэдэг нь ч тодорхой бус..//минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Аудитын газрын дарга. 5 номер хариулья. Д.Загджав.

**Д.Загджав:** Улсын Их Хурлын байнгын хороодын дарга, эрхэм гишүүд ээ, П.Батчимэг гишүүний асуултад хариулья.

Бид аудитыг яг байгаа байдал дээр нь үнэлж дүгнэсэн юм. Ер нь олон удаагийн хурал зөвлөгөөн дээр яриад л байгаа л даа. Ер нь эдийн засгийн тооцоо судалгаа, үндэслэл муу байна гээд. Ийм л байгаа юм. Тэгээд ийм байгаа юмыг энэ байдлаар нь дүгнэсэн. Аудитыг бас дүгнэдэг олон улсын стандарт гэж байна. Тэр дагуугаа л бид хараат бусаар дүгнэсэн.

Тэгэхээр түүн дээр Засгийн газрыг өмөөрсөн, талд нь орсон юм бол байхгүй.

**Ж.Бат-Эрдэнэ:** П.Батчимэг гишүүн тодруулна. П.Батчимэг гишүүний микрофоныг нээе.

**П.Батчимэг:** Зүгээр би сая Үндэсний аудитын газрын тайлантай ингээд нэг бүрчлэн танилцсан юм л даа. Бүр 2022 оны тайланг авч үзсэн, төлөвлөгөөний гүйцэтгэл харсан. Тэгэхэд энд 60.1 хувьтай, 2023 оных нь болохоор 70.8 хувьтай. Тэгээд энэ жилийн 2024 оных нь болохоор 52.1 гэсэн ийм төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүн гарчихсан байгаа юм.

Тэгэхээр ер нь аудитын газар сая хэллээ. Дарга. Тийм ээ. Засгийн газар тал засаад байгаа юм ер нь бол байхгүй байгаа. Тэгвэл энэ өгч байгаа энэ зөвлөмж, гаргаж байгаа санал, дүгнэлтээ хэр бодитой барьж, цаашид энэ төсвийг захиран зарцуулагч сайд нар ажлаа хийх, энэ хяналт тавих, энэ үйл ажиллагаанд нь хяналт тавихад ямар зарчим Та үйл ажиллагаандаа авч хэрэгжүүлж яаж ажиллах юм. Зүгээр ингэж хэлчхээд л, манайх ингээд л дүгнэчихсэн. Тэгээд л ингээд л дүгнэдэг гээд яваад байх юм бол ер нь ажил чинь, энэ Засгийн газрын ажил, энэ улс эх орны ажил явах уу?

**Ж.Бат-Эрдэнэ:** Д.Загджав дарга тодорхой асуулт асуугаад байна шүү дээ. Энэ 10 хүн ирсэн байна. Танайхаас. Баахан аудиторууд байна. Яг энэ дээр ажилласан аудиторынхаа хариултыг нь сонсъё л доо. 6 номер. Хэн бэ? Д.Энхболд. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захидал, Тэргүүлэх аудитор уу? 6 номер. Нэрээ хэлээрэй.

**Д.Энхболд:** Д.Энхболд. Үндэсний аудитын газар. П.Батчимэг гишүүний асуултад хариульяа.

Түрүүний дүгнэлттэй холбоотой энэ дүгнэлтийг юунд үндэслэж ингэж дүгнэлт хийсэн бэ гэдэг асуултыг асуусан.

Тэгэхээр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд нь заасан байгаа юм. Урт болон богино хугацааны зорилтыг тавихдаа тоон болон шалгуур үзүүлэлт тухайн үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшнийг тодорхойлох.

Хоёрт нь, хүн, нийгэм, эдийн засагт тухайн арга хэмжээ хэрэгжээд ямар зэрэг үр нөлөө авчрахыг үр дагавар авчрахыг тодорхойлох.

Тэгээд санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй уялдуулан нарийвчлан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хавсаргах ёстой гэдэг ийм үзүүлэлтүүдийг хангаагүй учраас иж бүрнээр нь төлөвлөж чадахгүй байна.

Ийм учраас дутуу төлөвлөсөн ажлыг бид энэ шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх бололцоогүй байна гэдэг ийм дүгнэлтийг хийгээд, энэ шалгуур үзүүлэлтүүдийгээ тэргүүлэх чиглэл, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** 6 номерын микрофоныг сунгаяа.

**Д.Энхболд:** ...бодитойд тооцдог байх. Дээрээс нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар салбар тус бүрийн онцлогт тохирсон аргачлалыг бий болгоно гэдэг ийм заалттай. Энэ заалтыг төсвийн ерөнхийлөн захирагч нар хэрэгжүүлж ажиллаач ээ гэдэг ийм зөвлөмжийг өгч ажилласан байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** П.Батчимэг гишүүн.

**П.Батчимэг:** Аудитын газрын үйл ажиллагаа, тэгээд хийж байгаа ажлыг бол би үгүйсгэсэн юм байхгүй л дээ.

Үнэхээр уншаад, үзээд судлаад харахаар сайн хийж байгаа юу гэвэл энэ ажлыг маш сайн хийгээд бас дүгнэлтээ үнэхээр чадлын хэрээр сайн хийчихсэн байгаа юм.

Гол нь энэ Их Хурал хийсэн, Тамгын газрын хийсэн Хяналт шинжилгээ, мониторингийн газрын хийсэн дүгнэлт, тэгээд Засгийн газрын өөрсдийнх нь дүгнэлт, танай аудитын газрын дүгнэлтийн хоорондын уялдаа холбоо, тэр гаргаж ирсэн дүн, үзүүлэлт нь нэлэн зэрүүтэй байгаа. Энэ дээр би бас их гайхаад байгаа юм.

Тэгээд ер нь аудитын газар ажлаа хийгээд өгчихсөн бол гишүүддээ бас жоохон эртхэн шиг өгчхөж баймаар байна. Яг энэ ташрамд хэлэхэд энэ олон албаны хүмүүсийн том бүтцийг дандаа хуралдаануудаар оруулж ирдэг асуудлыг ер нь хаана зохицуулж, яаж яах вэ? Ж.Бат-Эрдэнэ дарга сая хэлсэн. Тийм ээ. Ер нь ингэж олуулаа ирж энэ ажлын цагийг үрж.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** 5 номер.

**Д.Загджав:** П.Батчимэг гишүүний асуултад нэмж хариулт өгье.

Бид хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиар тайланг 2 сарын 15-ны дотор аваад, тэгээд 3 сарын 15-наас өмнө Улсын Их Хуралд хүргүүлэх хуультай байдаг. Тэр дагуугаа л хүргүүлсэн байгаа. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** С.Цэнгүүн гишүүн.

**С.Цэнгүүн:** Өдрийн мэнд. 2021-2025 онд бид 21 их наяд төгрөгийг энэ төлөвлөгөөнд зарцуулсан байна.

Тэгээд энэ төлөвлөгөө дээр болохоороо тэр нь эдийн засаг, нийгмийн ямар үр нөлөөтэйг чухаллахгүйгээр батлагдсан тул хэрэгжүүлнэ гэсэн бодлогоор явжээ гээд аудитад дүгнэчихсэн байгаа юм.

Эндээс харахаар “Алсын хараа-2050” гэдэг үндсэн бодлого чинь өөрөө хэрэгжих боломжгүй, ач холбогдлын дараалалгүй учраас ийм байдал дээр авчирчхаад байна шүү дээ. Үндсэн том малгай концепц чинь өөрөө болохгүй байна гэдгийг хэлмээр байна.

Ер нь энэ 5 жилийн төлөвлөгөө гээд нэг социализмын үед баталдаг байсан шиг ийм юмтай. Тэгээд тэр 5 жил нь болоод биелэгдэхгүй болохоор

ахиад хугацаагаа уртасгаад тавьчихья гэдэг ийм шийдэл яриад сууж байдаг. Бид ер нь цаашид ингэж яваад байх боломжгүй л дээ.

Тэгээд Эрчим хүчний яамнаас асуумаар байна. Гүйцэтгэлийн тайлан дээр салбарын эдийн засгийн үр өгөөжтэй болгоно гээд тэгсэн. Шалгуур үзүүлэлт нь болохоороо эрчим хүчний компаниудын санхүүгийн алдагдлыг багасгана гэсэн байгаа. Гэтэл Эрчим хүчний яам өөрөө энэ үзүүлэлтээ болохоор 100 хувиар биелсэн гээд үзчихэж. Эдийн засаг, хөгжлийн яамнаас үүнийг 0 хувь гээд тавьчихаж. Ийм том ялгаатайгаар. Одоо хасах 75 тэрбум гээд байж байна л даа.

Үгүй, ер нь энэ шинээр бүрэлдсэн Улсын Их Хурал бол Эрчим хүчний яамныг маш сайн дэмжсэн. Үнэ, тариф өөрчлөхтэй холбоотой асуудлуудыг. Би өөрөө галыг нь аваад урд талд нь төсөв барих бүх зүйлүүдээр нь хамгаалаад явсан. Энэ салбарт зайлшгүйгүй хөрөнгө оруулалт хэрэгтэй гээд. Энэ цаг мөчөөс хойш 6 сар өнгөрлөө. Эрчим хүчний яам хаалгаа хаагаад алга болсон. Үүнийг бас Улсын Их Хурлын гишүүдэд би хэлье гэж бодож байна.

Ямар ч мэдээлэл өгөхөө больсон. Эрчим хүчний яам. Зүгээр жишээ гээд хэлэхэд цахилгаан түгээхээс Та бүхэн одоо ямар төлөвлөгөөтэй ажиллаж байна, түгээх салбарын либералчлалтай холбоотой мэдээллүүдээ өгөөч ээ гэхэд хуулийн хугацаанд албан бичгээр хандаж байхад хариугаа өгөөгүй. Албан бус байдлаар яамны сайд, Б.Чойжилсүрэн сайдын зөвшөөрөлтэйгөөр өгнө гээд тэгсэн. Энэ юу гэсэн үг юм. Б.Чойжилсүрэн сайд тэгвэл яаж ажиллах гээд байгаа юм.

Бид эрчим хүчний реформ гээд маш хүчтэйгээр гурван нам хамтраад явж байхад өнөөдөр Эрчим хүчний яаман дээр байгаа хүмүүс нь ажлаа хийж чадахгүй байгаад байна.

Энэ зах зээлийн загварчлал, үнийн бодлого, шинэ өрсөлдөөн, шинэ төслүүдийг тусгай зөвшөөрлөөр нь боогоод байгаа шүү дээ. Маш олон хөрөнгө оруулагч нар орж ирээд орох гээд Эрчим хүчний яам боогоод байгаа шүү дээ. Энэ бодитой байхгүй юу. Би үүнийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэнгээс асуумаар байна. Өнөөдөр хуралдаа ирээгүй байна.

Н.Учрал сайдаас бас асууя. Энэ эрчим хүчний компанийн санхүүгийн алдагдлуудаа бууруулна гээд чадахгүй байгаад байна шүү дээ. Тэгээд одоо энэ хүмүүстээ хариуцлага хүлээлгэх юм уу, яах юм. Улсын Их Хурал дээр эсвэл энэ асуудлыг оруулж ирэх юм уу? Та хариуцлагатайгаар энэ дээр бас хариулаад өгөөрэй.

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Чойжилсүрэн сайд байхгүй. Тийм ээ. Н.Тавинбэх Төрийн нарийн бичгийн дарга.

**Н.Тавинбэх:** С.Цэнгүүн гишүүний асуултад хариульяа.

Эх үүсвэр барихтай холбоотой яаман дээр гацаасан зүйл огт байхгүй. Бид ирсэн бүх хүсэлтийн дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эх үүсвэр барих тусгай зөвшөөрлүүдийг хатуу түлш болоод сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд дээр өгч байгаа. Өгч байгаа.

Өнөөдрийн байдлаар 11 аж ахуйн нэгжид экспортын зориулалттай болоод дотоодын хэрэгцээнд хангах зориулалттай нүүрсний эх үүсвэрүүдийг хатуу түлшээр ажилладаг технологитой эх үүсвэр тусгай зөвшөөрлийг нь өгчихсөн.

Харин ганцхан зүйл байгаа. Ганцхан зүйл байгаа. Би хатуу хэлье.

Өнөөдрийн эрчим хүчний салбарт үүссэн нөхцөл байдал бас энэ тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал байгаа. Манай энэ тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийнхэн гэрээнийхээ үүргийг цаг хугацаандаа биелүүлэхгүй байгаатай холбоотойгоор салбарт үүсэж байгаа, ялангуяа энэ чадлын дутагдалд орж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд гэрээнийхээ үүргийг биелүүлэх шаардлага тавихаар, зэрэг эсвэл гэрээг цуцлах болохоор ингээд хамаатай хамаагүй янз бүрийн шалтгаан бариад явдаг. Тэрийг нь буруу зөрүү ойлгож бүх түвшинд шаҳдаг нэг ийм л юм байгаа юм.

Яам бол нэг ч аж ахуйн нэгжид. Та тодорхой жишээ байвал хэлээрэй. Ямар аж ахуйн нэгж хүсэлт өгөөд шийдэхгүй хохироосныг хэлэх юм бол бид одоо тайлбар өгье.

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн хувьд 2019 онд хууль өөрчлөгдсөн. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд хөрөнгө оруулах сонирхолтой хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулалтаар шалгаруулдаг болсон. Бид бэлтгэл ажил хангaad хэмжилт туршилт хийгээд явж байгаа. Удахгүй эхний сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барих, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аукцион зохион байгуулагдана.

**Ж.Бат-Эрдэнэ:** С.Цэнгүүн гишүүн тодруулна.

**С.Цэнгүүн:** Энэ QLEANTECH компанийн асуудлыг ердөөсөө өнгөрсөн намараас эхлээд л сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой төслүүд яригдаж эхэлснээс хойш албан бичгүүдээ явуулаад байгаа. Бүх гишүүд дээр ирж байгаа. Эрчим хүчний яам руу ч гэсэн тайлбаруудыг нь тавьдаг.

Ингээд өөрсдийгөө хамгаалсан байдлаар яриад байгаа байхгүй юу. Ерөөсөө энэ дээр Монгол-Германы хамтарсан 100 мегаваттын салхин цахилгаан станцын төсөл байгаа.

Хэрэгжиж чадахгүй олон жил болж байгаа. Тусгай зөвшөөрлийг нь нэг жилээр өгдөг. ТЭЗҮ-гээ тааруулаад Диспетчериин үндэсний төвтэй үнэ тарифаа тохируулах гээд явж байх хооронд нь энэ тусгай зөвшөөрлийн хугацаа нь дуусчихдаг. Тэрийгээ үргэлжлүүлээд явъя гэхээр Диспетчериин үндэсний төв нь Эрчим хүчний яамтай ярь. Тэрийг ярьж байж л шийднэ гэсэн байдлаар хандаад байгаа.

Энэ гаднын хөрөнгө оруулагч нь бүр гайхчихсан. Бид энэ төслөө хийх юм уу, хийхгүй юм уу гээд гайхаад албан бичгүүдээ говийн бүсээс сонгогдсон Их Хурлын гишүүд рүү явуулсан байгаа юм. Эрчим хүчийг дэмжих 103 дэмжих бүлгийн гишүүд рүү явуулсан. Ингээд энэ болгоныг бүгдийг нь Эрчим хүчний яам руу хандаад байгаа юм. Эрчим хүчний яам ажлаа хийх.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** 2 номер.

**Н.Тавинбэх:** QLEANTECH гэдэг компани 2017 онд 202 мегаваттын хүчин чадалтай салхины станц барихаар тусгай зөвшөөрөл авч Эрчим хүчний диспетчериин үндэсний төвтэй цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулсан байгаа.

Энэ 202-ын 102 нь дотоодын хэрэгцээнд нийлүүлэхээр, 100 нь экспортод гаргахаар гэрээ байгуулсан.

Харамсалтай нь өнөөдрийг хүртэл нэг ширхэг хадаас ч хадаагүй. Тэр компанийн хийдэг зүйл ордноор явж ташаа мэдээлэл тараадаг л юм байгаа.

Бид цаашид бусад хөрөнгө оруулагч нарыг нээлттэй болгохын тулд, боломжийг хангахын тулд аукционоор сонгон шалгаруулахын.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Учрал сайд. Ажлын хэсэг. 2 номер.

**Н.Тавинбэх:** Гэрээний үүргээ, тусгай зөвшөөрлийнхөө хугацаанд биелүүлээгүй компаниудтай хариуцлага тооцож байгаа. Энэ зүй ёсны хэрэг. Үүний цаана чадлын дутагдалд орж байна. Технологи, тоног төхөөрөмжийн үнэ хямдарсантай холбоотой хэрэглэгчид очдог сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн үнэ буурах боломж байгаа учраас бид хариуцлага тооцож байгаа.

Ийм хариуцлагагүй компаниудыг өөгшүүлээд байдаг байж таarahгүй.

2017 он. Өнөөдөр 8 жил болж байна. Ширхэг хадаас хадаагүй. Та очиж үзэж болно. Газар дээр нь. Олон удаа бид ажлын хэсэг гаргаж ажиллаж байгаа,

зөвшилцэж байгаа. Нэг ч арга хэмжээ аваагүй, нэг ч юм хийгээгүй. Тэгээд мөнгө бэлэн. Ажил хийх гэхээр Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо гацаадаг нэг ийм тайлбартайгаар нэг хэсэг улсууд яваад байгаа.

Яг сайн яривал тэр тантай уулзаад яриад байгаа улсууд тэр компанид огт хамааралгүй улсууд явж байгаа шүү. Тэгээд ийм юмаар бизнес хийдэг.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Тавинбэх Төрийн нарийн бичгийн дарга аа, яг одоогоор хэдэн тусгай зөвшөөрөлтэй, хэдэн тусгай зөвшөөрөлтэй компани байгаа вэ гэдэг нэг тоо хэлээдэх дээ. Тоо хэлээдэх дээ. Б.Пүрэвдорж гишүүн боль. Чимээгүй байгаарай.

**Н.Тавинбэх:** Б.Пүрэвдорж гишүүн ээ. Надад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй тусгай зөвшөөрөл авсан компаниудад нэг ч оролцоо байхгүй гэдгийг хэлье.

38 аж ахуй нэгж...

**Ж.Бат-Эрдэнэ:** Хэдэн компани байна? Хэлээдэх дээ.

**Н.Тавинбэх:** 2007 оноос хойш 2019 оныг хүртэл 38 аж ахуйн нэгжид 1580 мегаваттын хүчин чадалтай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барих...

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Пүрэвдорж гишүүн боль боль.

**Н.Тавинбэх:** Тэгээд асуулт асуух юм. Хариулах юм. Тэгээд яах ёстой юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Яг хэдэн компани байна? Хэлээдхээч. Яг хэдэн компани байгаа юм? Үйл ажиллагаа явуулаагүй хэдэн компани байна?

**Н.Тавинбэх:** 2007 оноос хойш 2019 оныг хүртэл 38 аж ахуйн нэгжид 1560 мегаваттын хүчин чадалтай сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барих зөвшөөрлийг олгосон байгаа. Хуучин хуулийн орчинд.

Эндээс 8, 9 нь ашиглалтад орсон. Цаг хугацаандаа. 8-аас бусдыг нь гэрээний үүргээ биелүүлээгүй гэж хүчингүй болгосон байгаа. 8 аж ахуйн нэгж ажлаа эхэлсэн. Тэр дотор шүүхийн маргаантай, саяын QLEANTECH шиг аж ахуйн нэгжүүд явж байгаа. Ажлаа хийж байгаа бид нар.

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Учрал сайд.

**Н.Учрал:** Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаа энэ 14 эрх зүйн реформ. Энэ хүрээнд төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах ажил туссан.

Энэ хүрээнд бид уул уурхайн компаниудыгаа “Эрдэнэс Монгол” нэгдэл дээр, уурхайн бусыгаа “Эрчист Монгол” нэгдэл дээр гээд чиг үүргийн давхардлыг арилгая л гэж зорьж байгаа юм.

Засгийн газрын бодлого салбарын яамдыг аж ахуйн ажлаас холтгох, цаашлаад бодлого руу нь ороод яг тэр гүйцэтгэлийнх нь аж ахуйн ажил руу нь тэр нэгдэл нь өөрөө ашгийнхаа төлөө ажиллах ийм нөхцөл байдал руу оруулахаар ажиллаж байгаа.

Тэгээд энэ хүрээндээ сая өнгөрсөн долоо хоногийн Засгийн газрын хурлаар “Эрчист Монгол” төрийн өмчит хариуцлагатай компанийн дэргэд...

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Учрал сайд.

**Н.Учрал:** Засгийн газрын хурлаар “Эрчист Монгол” компани дээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоолыг баталсан.

Энэ хүрээнд уурхайн бус компаниуд, тэр дотроо эрчим хүчний компаниуд энэ “Эрчист Монгол” руугаа нэгдээд ажиллана. Эхний хүрээнд 66 хувь нь хувьцаа эзэмшигчийн эрхийг нь “Эрчист Монгол” хэрэгжүүлнэ 34 хувийг нь Эрчим хүчний яам хэрэгжүүлнэ. Ийм л шийдвэр гарсан.

Тэгэхээр цаашдаа Эрчим хүчний яам өөрөө бодлогын дэмжлэг үзүүлээд салбарын бодлогоо хариуцна.

Түүнээс биш тэр “Эрчист Монгол” нэгдэл дээрээ менежментийг сайжруулах чиг үүргийн давхардлаа арилгах ажил хийгдэнэ.

Тэгэхээр Төрийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдлын нэмэгдүүлэх хууль Их Хурлаар орсонтой холбогдуулаад энэ хууль батлагдсаны дараа төрийн өмчит компаниудаар баримтлах үндсэн чиглэлийг Их Хуралд оруулж ирнэ. Тэр үед бид эрчим хүчний компаниудыг нэгтгэх, нийлүүлэх, шинээр өөрчлөн зохион байгуулах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлээд явах болно гэдгээ хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** С.Цэнгүүн гишүүн тодруулъя

**С.Цэнгүүн:** Н.Учрал сайд аа, тэгээд би ерөөсөө ирээдүйд яах вэ гэдэг талаар асуугаагүй. Өөрөөс чинь. 2021-2025 онд энэ чинь ажлаа хийгээгүй байна шүү дээ. Хийж чадаагүй байна.

Тэгэхээр энэ хүмүүсдээ яах юм? Эрчим хүчний яамны харьяанд байгаа Төрийн өмчит компаниудын алдагдлыг бууруулаагүй. Одоо албан тушаалаа

үргэлжлүүлээд хашаад явж байгаа энэ хүмүүсийг яах юм? Бид. Хариуцлага яах юм?

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Учрал гишүүн.

**Н.Учрал:** Эрчим хүчний яаман дээр жилийн өмнө билүү. Энэ чинь хэзээ шилжлээ. Энэ эрчим хүчний компаниуд шилжсэн. Тэгээд одоо буцаад “Эрчист Монгол” дээр шилжээд ирж байна гэж байна. Нэгдэл болоод.

Тэгэхээр одоо бид Төрийн өмчийн хороо ч тэр, тэр “Эрчист Монгол” нэгдэл ч тэр хариуцлага ярих. Одоо тэр ТҮЗ-ийнх нь дэргэдэх дотоод аудитыг нь оруулъя. Тэгээд дотоод аудит нь дүгнэлтээ гаргаг. Ингээд тэр эрчим хүчний компаниуд дээр үнэхээр хариуцлага ярих асуудал байвал бид зохих арга хэмжээнүүдийг авна. Одоо л наадах чинь нөгөө “Эрчист Монгол” дээр ингэж хувьцаа эзэмших эрх нь шилжиж ирж байгаа. Өмнө нь яам дээрээ л байсан гэсэн үг.

Ер нь цаашдаа бид тэр зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлөө өгдөг. Тэгээд ингээд хяналт хэрэгжүүлэлтийг явах ч гэсэн яг засаглал руу нь энэ нэгдэл дээрээ л явах нь зөв.

Тийм учраас энэ хариу арга хэмжээг ойрын хугацаанд авна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Энэ засаг дээр миний чиний сайд, энээ тэрээ гэсэн юм байхгүй шүү. Адилхан л асуулт асууж, адилхан л шаардлага тавьж байгаа шүү. Яах гэж ер нь засаг нэгдсэн юм. Адилхан хариуцлага үүрэх гэж л ороо биз дээ.

Түүнээс биш эх барьж байгаа нь илүү хариуцлага үүрч загнуулна. Нөгөөдөх нь загнуулахгүй, шаардлага тавиулахгүй гэсэн асуудал байхгүй шүү ер нь. Янзын юм ярьцаагаад.

Түрүүн М.Мандхай гишүүн асуулт асуусан. Ц.Болорчулуун асуултыг сонссон уу? Ц.Болорчулуун. Хэдэн номер вэ? Микрофон дээр суу. 9 номер.

Өөрийгөө танилцуулаарай.

**Ц.Болорчулуун:** М.Мандхай гишүүний асуултад хариульяа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун.

Тэгэхээр хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрийн салбар дээр 5 төрлийн үндсэн урамшуулал явж байгаа.

Ноосны, арьс ширний, сүүний, улаан буудайн, хүнсний ногооны гээд.

Бүх урамшууллууд ер нь цахим систем дээр татварын и-баримтад тулгуурлаж явж байгаа. Жил бүр программ хангамжаа сайжруулах зориулалттай тодорхой хэмжээний төсвийг тавиад явдаг.

Энэ хүрээнд газар тариалангийн [plant.mofa.gov.mn](http://plant.mofa.gov.mn) гээд программ дээр тодорхой хэмжээнд төсөв тавиад үүнийг сайжруулалтыг нь хийгээд явсан байгаа.

Энэ ажил бид нарын төлөвлөсөн ажил байсан учраас тэр хэмжээндээ сайжруулалтаа хийсэн учраас 100 хувь гэж үнэлэгдсэн байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** М.Мандхай гишүүн тодруулна.

**М.Мандхай:** Яах вэ, НӨАТ-ын систем чинь нөгөө түүхий эдээсээ эхлээд үйлдвэрлэгч, эцсийн хэрэглэгч хүртэлх дамжлага, хяналтын системийг нь сайжруулах үүднээс цахимжуулж байгаа шүү дээ.

Тэгэхээр одоогийн байдлаар яг үндсэндээ ченж малчид энд бүртгэхгүй, түүн дээр хяналт байхгүй байгаа.

Тэгэхээр тэд нарын түүхий эдийг бүртгэхгүй учраас үйлдвэрлэгчид өөрсдөө НӨАТ-ын өрөнд ороод байна гэдэг асуудлыг үйлдвэрлэгчид яриад байгаа юм.

Тэгэхээр цахимжуулснаараа энэ хяналтыг яаж сайжруулах гэж байгаа юм бэ?

Хоёрдугаарт, би асуулт асуусан нь “Шинэ хоршоо”, “Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”-ын хүрээнд хэрэгжих гэж байгаа. Одоо “Хүнсний хувьсгал” бол 2022 оноос хойш хэрэгжээд явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр хүнсний аюулгүй байдлыг хангах, хангамжийн гол тэргүүлэх чиглэл чинь өөрөө ямар ч хянах индикатор үзүүлэлт нь байхгүй. Тодорхойгүй гэдгийг аудит дүгнээд гаргачихсан байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** 9 номерын микрофон.

**Ц.Болорчулуун:** Ер нь анхан шатны малчдаас, тариаланчдаас гарч байгаа түүхий эдийг үйлдвэрт тушаахад үйлдвэрүүд энэ татварын и-баримтад бичиж өгч байгаа.

Тэгэхээр энд үйлдвэрт шууд тушаагдахгүй байгаа нь энд тодорхой хэмжээнд хамрагдахгүйгээр өнгөрч байгаа. Тухайллах юм бол бид жилдээ 30 мянган тонн ноосны гарах потенциал боломжтой байхад урамшууллаар авагдаж

байгаа нь, үйлдвэрт тушаагдаж байгаа нь 9 мянга гаруй тонн ноос л тушаагдаж байгаа юм.

Тэгэхээр энэ яг и-баримтад бичигдэхгүй байгаа хэсэг нь үлдэж байна л гэсэн үг.

Тэгэхээр цаашдаа үүнийг бид боловсронгуй болгох, үйлдвэрүүд бүрэн хэмжээгээр түүхий эдээ авах энэ бололцоо нөхцөлийг нь харахын тулд л энэ программ чинь сайжруулалтыг нь хийж л явж байгаа л асуудал байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** М.Мандхай гишүүн. Хэд тодруулчав даа. Энэ чинь.

**М.Мандхай:** Гол нь та хэд энд үнэлэхдээ 90-ээс 100 хувиар үнэлчихсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг энэ үлдэгдээд байгааг чинь ерөөсөө хянах энэ систем чинь өөрөө бүрэн хянаж чадахгүй байгаа гэдгийг л хэлээд байгаа юм. Хэдүүлээ чинь үнэлгээний систем ярьж байгаа юм.

Хоёрдугаарт, гол энэ хөдөлгөөн явж байгаатай холбоотой гүйцэтгэл өөрөө хангалтгүй байгаад байна л даа. Жишээлбэл, та хэд 90 хувийн гүйцэтгэлтэй гээд Эмээлтийн үйлдвэр технологийн паркийг тавьчихсан байгаа. Дэд бүтэц нь тийшээгээ байхгүй учраас үйлдвэрлэгч нар орж чадахгүй байгаа. 90 хувийн гүйцэтгэлтэй гэхээр чинь яг үндсэндээ Тамга дээр үүнийг яг бодит байдалтай нь шалгаад 50 хувийн гүйцэтгэлтэй гээд гарчихсан байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг нийслэл хариуцах юу, эсвэл яам хариуцаж байгаа юу? Нийслэл Эмээлт гэхээр чинь дэд бүтцийг нь оруулж өгөх ажил нь ч юм шиг.

Тэгэхээр энэ дээр яг бодитой хариул. Үйлдвэр, технологийн паркийг бид барьж дуусгахгүй бол “Цагаан алт, “Хүнсний хувьсгал”, “Шинэ хоршоо” гэдэг хөдөлгөөн хэрэгжээд баахан санхүүжилт гаралт үр дүнгүй асуудалд орохоор харагдаж байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** 9 номерын микрофон. Нэрээ танилцуулаад хариулна шүү.

**Ц.Болорчулуун:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун. М.Мандхай гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Тэгэхээр яагаад 90, 100 хувиар үнэлэгдсэн гэхээр бид хоёр төрлийн программын хөгжүүлэлтийг нь, сайжруулалтыг нь хийнэ гэдгээр л тодорхой төсвийг тусгаад түүнийгээ хийчихсэн учраас тэр ажил бүрэн хийгдсэн гэж үзээд л үнэлгээ нь ингэж гарч байгаа асуудал.

Эмээлтийн үйлдвэр, технологийн паркийн хувьд энэ нийслэл дээр явж байгаа асуудал. Тэгээд Нийслэлээс хөрөнгө мөнгийг нь гаргаад, гаднын донор байгууллага, Дэлхийн банкны санхүүжилтээр тодорхой дэд бүтцийн асуудлууд яригдаад явж байгаа.

Бид бодлогын хувьд ер нь Эмээлтэд үйлдвэр, технологийн парк бий болгох нь зүйтэй гэдгээр дэмжиж ажиллаж байгаа. Бусад хөрөнгө оруулалтын асуудлыг нийслэл хариуцаж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Нийслэлээс хүн байна уу? Алга байна. Н.Учрал гишүүн.

**Н.Учрал:** Тийм. Гишүүддээ бас ойлгохыг хүсэж байна.

Яг зорилтот түвшиндээ хүрсэн байгааг нь л хэмжээд ийм дүгнэлт гаргачаад байгаа юм. Жишээ нь, сая тэр цахимжилт дээр дэвшил гарцаагүй биш гарсан байгаа юм л даа. Жишээ нь, энд би ингээд л харж байхад малын гаралтай түүхий эдийн экспорт, одоо ингээд бүх мэдээллүүд нь явчихсан. Тэгээд энд нэлээн урагшилсан зүйлүүд байгаа. Тэгэхдээ төлөвлөлт дээр бас алдаа байгаагаа бид хүлээн зөвшөөрөх ёстой.

Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдаад 2 жил болоод л, тэгээд л 2024 оны төлөвлөгөөг журмынх нь дагуу боловсруулаад баталсан.

Гэтэл нөгөө 2023 оноос хяналтын тогтолцоо хуулиар өөрчлөгдчихсөн. Одоо л яг үнэндээ учраа олж байгаа байхгүй юу. Анх удаа л энэ системээр явж үзэж байна шүү дээ.

Дээрээс нь Их Хурал хяналт шалгалтын хуулиараа дүн шинжилгээ хийх үүрэгтэй. Ийм эрхтэй. Гэтэл түрүүн Ч.Өнөрбаяр даргын хэлээд байгаа тэр 206 дугаар тогтоолыг чинь нэг бүрчлэн.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Учрал сайдын минутыг сунгая.

**Н.Учрал:** Тэгээд Засгийн газрыг үнэлдэг 206-г нь бариад Их Хурал нэг бүрчлэн үнэлчихээр энд нэг ийм зөрүү гарах нь ойлгомжтой болоод байгаа байхгүй юу.

Уг нь хяналт хэрэгжүүлэх хуулиар чинь Их Хурал дүн шинжилгээ хийх ийм эрх байгаад байдаг. Гэтэл хянаад, яг нөгөө Засгийн газрын хяналт хэрэгжүүлэхийг үнэлдэг аргачлал бариад 206-гаар нэг бүрчлэн үнэлээд тавьчихаар чинь энэ ийм том тооны зөрүү гарсан юм шиг харагдаад байгаа юм.

Тэгэхээр гишүүдээсээ хүсэхэд тэр жилийн төлөвлөгөө дээр яг хүрэхүйц зорилт нь юу гэж бичигдээд, түүнийг нь 90 хувиар яаж үнэлчихсэн юм бэ гэдгийг

харахгүй бол бүх ажил дууссаныг үнэлчихсэн биш шүү. Энэ бол жилийн төлөвлөгөө шүү гэдгийг ойлгох ёстой.

Тэгэхээр Эдийн засгийн хөгжлийн яам чинь анх Хөгжлийн бодлогын хуулиараа байгуулагдаад, тэгээд энэ чинь бараг жил болж байгаад сайд томилогдсон шүү дээ. Үндсэн хуулийн өөрчлөлтийн дараа. Тэгээд анх энэ механизмаар ажиллаж эхлээд, тэгээд анх удаа 5 жилийн чиглэл, хөтөлбөр гээд энэ ажлуудаа бүгдийг нь хийгээд явж байтал 2023 онд нөгөө хяналтын тогтолцоо чинь өөрчлөгдчихсөн байхгүй юу.

Тэгээд хяналтын тогтолцоо өөрчлөгдөөд явж байсан. Сая хамтарсан Засгийн газар байгуулагдах үеэр бүтэц, бүрэлдэхүүний хуульд өөрчлөлт орчихсон байхгүй юу.

Тэгэхээр яриад байгаа энэ жилийн төлөвлөгөө чинь энэ хуулиас өмнө барьчихсан төлөвлөгөө болчоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид одоо л яг амьдрал дээр энэ нийцлүүдийг нь хараад, алдаа оноогоо хараад урагшилж байна л гэж ойлгох ёстой байх. Тэгээд Их Хурлын хяналтын хуулиар аваачаад бид Засгийн газраас хяналт хэрэгжүүлгийнхэн дүгнэсэн үнэлгээгээ өгчихдөг. Тэнд нь очиж хяналт хийхдээ тэр хяналт хэрэгжүүлгийн 206-г бариад нэг бүрчлэн үнэлчихдэг. Тэгэнгүйт аудитын хийсэн тайлантай нэг ийм зөрөөд байгаа юм шиг харагдаад. Тэгээд яг үнэндээ бид чинь яг зөв индикатораа хэрэглэж чадахгүй. Таны хэлдгээр нөгөө чанарын аргыг баримтлах уу, үгүй юу гэдгийг шийдээгүй. Тэгээд Засгийн газар сая баталсан үнэлгээний аргачлалын дагуу яваад байдаг.

Тэгэхээр нэг иймэрхүү асуудал байгаа шүү.

Тийм учраас төлөвлөлт дээр алдаа байна уу гэвэл байна. Яагаад гэхээр энэ төлөвлөлт анх хийгдэхдээ өнөөдөр эрх зүйн орчин өөр байсан. Гэхдээ энэ болгоныг бид засаж засварлаад явж байна. Энэ хаврын чуулганаар төрийн албаны реформ, нийтийн албаны хуулийг хийхэд бүтэц, бүрэлдэхүүний хооронд үүсээд байгаа гажуудлууд, асуудлуудыг бид цэгцтэй нэг мөр хараад шийдвэрлэнэ.

Тэгээд энэ асуудлаар Э.Одбаяр сайд, Л.Гантэмэр сайдтай бид ажлын хэсэг байгуулаад хууль эрх зүйн орчин дээр ч гэсэн эргэж харах зохицуулалтуудаа хийгээд явж байгаа. Тэгээд үүнийг эрхэм гишүүд Тэгээд үүнийг эрхэм гишүүд Та бүхнийг ойлгохыг хүсье.

**Ж.Бат-Эрдэнэ:** П.Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Өдрийн мэнд.

Би цөөн хэдэн асуултыг л асууя. Одоо бас яах вэ, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлээд б сар гаруй болж байгаа учраас хараахан бодит үр дүнгүүдийг гаргахад хэцүү байх. Тэгэхдээ энэ б сарын хугацаанд ажлууд яаж хэрхэн тавигдсанаар цаашдаа энэ ажлууд хугацаандаа дуусах уу, угүй юу гэдэг зүйлүүд байгаа байх.

Тэгэхээр “Ногоон хөгжил” гэж бид их ярьж байгаа. “Ногоон эдийн засаг” гээд. Ерөнхийдөө бид энэ чиглэлдээ ярьдаг боловч яг бодлогын зарим алхмууд хийгдэх тал дээр дутагдалтай байгаа. Яг үүнийг дэмжсэн хууль эрх зүйн орчин дутуу дулимаг учраас яриад байдаг. Энэ чиглэлийн хөрөнгө оруулалт байдаг юм уу, энэ чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх тал дээр концепцын байдалтай. Яах вэ, моод болгож л яриад байна л даа.

Тэгэхээр бид хэд энэ дээр ямар ахиц дэвшил байна вэ? Ялангуяа сэргээгдэх эрчим хүчний хууль эрчим хүчний хуулиар явах бололцоогүй. Одоо цэвэр эрчим хүчний асуудлууд байгаа шүү дээ. Атомын цахилгаан станц.

Дээрээс нь сүүлийн үед энэ яг сэргээгдэх эрчим хүч мөн байна уу, угүй юу? Энэ газрын дулааныг ашиглаж байгаа асуудал. Зарим туршилтын буюу хэрэглээнд оруулаад байгаа боловч бодит байдал дээрээ үүнийг хууль эрх зүйн талаасаа зөв зохицуулж өгөхгүй бол хөрөнгө оруулалт болон хэрэглэгчийн эрх ашгийг дараа нь яаж хамгаалах вэ, үүнээс үүсэх үр дагаврыг хэн хариуцах вэ гэдэг зүйлүүд тодорхойгүй яваад байдаг.

Тэгэхээр үүнийг үндсэндээ эрчим хүчний реформын хувьд юм уу, яг цэвэр эрчим хүчний тухай хуулийг өргөн бариач ээ гэдэг зүйлийг би уг нь төсөв баталсан, дагаж гарсан тогтоол дээр оруулж өгсөн.

Ногоон эдийн засгийг дэмжих тухай хуулийг оруулж ирээч ээ гэсэн.

Сайдууд маань их уулгамч л даа. Оруулж ирнэ. Ёстой зөв юм ярилаа гээд л байдаг. Яг б сарын хугацаанд юм орж ирсэнгүй. Юм орж ирсэнгүй. Өмнөх Засгийн газрын үед яригдаж байсан хэдэн хэлэлцээрүүд л орж ирлээ.

Яах вэ, мэдээж энэ парламент, Засгийн газар үүнийгээ улс төрийн хувьд ойлголцоод энэ том төслүүдийг хөдөлгөж байгаа боловч бодитой яг хууль эрх зүйн реформын юмнууд юу ч орж ирсэнгүй.

Тэгэхээр би яг энэ “ногоон эдийн засаг” гэдэг юм уу, “ногоон хөгжил”-ийн асуудал дээр ер нь ялангуяа тэр Цэвэр эрчим хүчний хууль, Ногоон эдийн засгийг дэмжих тухай хууль хэзээ орж ирэх вэ гэдэг зүйлийг тодорхой асуумаар байна.

Хоёрдугаарт, улсын болон дагуул хотыг хөгжүүлэх чиглэлийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүд ер нь ямар явж байна аа? Яг тодорхой

маш олон зүйлүүдийг ярьж ярьж байгаа. Аль хэсэг дээр фокуслаад бид хэд явах ёстой юм бэ? Маш олон зүйлүүдийг зэрэг эхлүүлж чадахгүй байна.

Тэгэхээр үүнийг Эдийн засгийн хөгжлийн яам байдаг юм уу холбогдох яамд нь яг юу гэж бодож байна? Үүнийг тодорхой хариулж өгөөч.

Дээрээс нь энэ боловсролын салбар бүр улс төржөөд дууслаа. Ерөөсөө намын мандат авахгүй бол, батлах авахгүй бол албан тушаалуудыг нь өөрчилж байна.

Энэ хүний хөгжлийн асуудал чинь энэ боловсролын салбар шүү. Боловсролын салбар яг ямар өөрчлөлтийг хийж энэ хүний хөгжлийн индексийг урагшлуулах гэж байгаа юм? Монгол хүний өрсөлдөх чадварыг яаж нэмэгдүүлэх гээд байгаа юм? Энэ намын асуудлаа.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** П.Сайнзориг гишүүний үгийг сунгая.

**П.Сайнзориг:** Энэ улс төржилтөө зогсоож болдоггүй юм уу? Боловсролын салбар. Энэ сайд нь байгаа юм уу, байхгүй юм уу?

Тэгээд эцсийн асуулт байна. Энэ төрийн хэмнэлтийн бодлогыг бүгд ярьдаг. Төр завсаргүй данхайж байгаа юм байна. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хууль байдаг юм уу, Засгийн газрын хууль дээр байгаа дэд сайдуудыг томилж чадахгүй байгаа мөртлөө ямар ч хуульд байхгүй баахан менежерүүдийг томилж байна. Энэ ер нь хэдэн орон тоо нэмчихсэн юм бэ? Энэ хэмнэлтийн бодлого явах юм уу, эсвэл хэдүүлээ үүнийг дэлгэцийн өмнө сонгогчдод иргэдэл зүгээр тааруулж бүгд амны уншлага болж ярьдаг болох юм уу? Бодитой үйлдэл нь хэзээ хийгдэх юм? Ямар арга хэмжээ авч байгаа юм? Энэ менежерүүд чинь юу хийх гэж байгаа юм бэ?

Тэгээд эцсийн дүндээ энэ дээр яг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр ярьж байхад Ерөнхий сайдыг орлох гурван Шадар сайдын хэн ч алга. С.Бямбацогт сайд байна, О.Алтангэрэл байна, Э.Одбаяр байна, Н.Учрал сайд байна.

Н.Учрал сайд бүхний сайд болоод бараг нэг нохойд барьдаг мод шиг л явж байна. Хөөрхий минь.

Тэгээд үг даахгүй хэдэн хүмүүс яг намынхаа сайдыг хамгаалаад байгаа юм шиг мөртлөө цаагуураа ер нь.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Учрал гишүүн хариулах уу? Бүхний сайд. С.Одонтuyaа сайд.

**С.Одонтуяа:** Эрчим хүчтэй холбоотойг нь дараа нь эрчим хүчнийхэн нэмээд хариулчхаарай.

Энэ “ногоон хөгжил”, “ногоон эдийн засаг” гээд бид их олон жил яриад төдийлөн урагшлахгүй байгаа. Үүнийг П.Сайнзориг гишүүн яг зөв олж харсан байна. Ер нь нийт манай эдийн засгийн 10 хувь нь л нэг ногоон байгаа.

Тэгэхээр 90 хувь нь бараг хүрэн эдийн засаг л болчхоод байна л даа. Тэгэхээр энэ дээр бид ямар ажлуудыг хийж чадсан бэ гэхээр энэ “Ногоон хөгжлийн корпорац” гэж олон улсын байгууллагууд олон жил гацсан. Энэ олон жил гацсан асуудал сая Засгийн газраар шийдэгдээд одоо энэ хөрөнгө мөнгө, бүх юмнууд нь үйл ажиллагаандaa ороход бэлэн болсон байгаа.

Тэгэхээр энэ асуудал шийдэгдээд явж байна.

Манай яамны хувьд бид энэ “ногоон хөгжил” гээд яриад яг ингээд очоод үзэх гэхээр хэтэрхий тархай байгаа.

Тэгэхээр хүн тавилга авьяа гэхээр Мишээл санагддаг шиг бид энэ байгальд ээлтэй технологи гэдгийг харьяа гэвэл хаана байх юм бэ гэдэг дээр манайх “смарт сити” буюу энэ байнгын үзэсгэлэнг нээх гэж байгаа.

Тэгэхээр энэ 3 орчим, 4 орчим га талбайд хийхээр иргэд болон аж ахуйн нэгжүүд байгальд ээлтэй технологийг сонгоё гэвэл шууд энэ үзэсгэлэнг зорихоор ийм зүйлийг бэлдээд хийж байгаа.

Ер нь энэ “ногоон хөгжил”, “ногоон эдийн засаг” гэхээр дэлхий дээр энэ улс орнууд ерөөсөө том эдийн засгийн зах зээл болчихсон юм байна. Тэгээд хувийн хэвшлийн оролцоотойгоор хувийн хэвшил өөрөө энд сонирхолтой байж энэ нь хөгжөөд байгаа юм.

Тэгэхээр удахгүй Эдийн засаг, хөгжлийн яам, манай яам хамтраад Уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг оруулж ирэх гэж байгаа. Энэ хуульд тэр карбоныг зохицуулсан зохицуулалтууд орж байгаа.

Манайх яам нийтдээ 12 хуулийн төсөл бэлдсэн. Энэ дээр хамгийн гол юм бол байгалийн нөөц ашигласны төлбөрийн хууль орно. Энэ хуулийн биелэлт анх 26 хувьтай байсан юм билээ. 2021 онд. 2023 онд 62 хувь болсон.

Тэгэхээр өөрөөр хэлбэл аймаг, сумд өөрсдөдөө орж байгаа төлбөрийг яг энэ “ногоон эдийн засаг”, энэ нойлоо шийдэх, хогоо шийдэх дээр төдийлөн сайн зарцуулахгүй байгаа учраас энэ дээр бид нэлээд ажиллагаанууд явуулж энэ асуудлыг нэмэгдэхээр ажиллаж байгаа юм.

“Ногоон хөгжил” дээр бид 173 том уурын зуухыг шинэчлэх ажил дээр яг энэ ногоон эдийн засгийн шийдлүүдийг шийдэхээр ажиллаж байгаа. Улаанбаатар хотын нийт 173 том уурын зуух, 2263 аж ахуйн нэгж нийт 150-иас 200 мянган тонн түүхий нүүрс түлж байгаа. Үүнийг бид бүгдийг нь өөрчлөхөөр ажиллаж байна.

Хэрвээ энэ зүйл амжилттай хэрэгжээд явбал айхтар хүрэн эдийн засгаасаа тодорхой хэмжээгээр салах юм.

Хамгийн гол нь банкны зээл байгаа. Одоо “ногоон зээл” гэхэд 15, 16 хувьтай гэхээр аж ахуйн нэгжүүд авч чадахгүй. Манай яаманд зээлийн зөрүү, “ногоон зээл”-д өгөөрэй гээд зээлийн дотацийн ердөө 1.2 тэрбум батлагдахаар. Энэ нь хаанаа ч хүрдэггүй.

Тэгэхээр бид төсөв батлахдаа зүгээр халамж, тусламж гэхээсээ илүү зээлийн дотацийнхаа дүнг нэмэгдүүлж чадах ёстой юм байна гэж үзэж байгаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** 9 номер. П.Наранбаяр сайд байгаа. 9 номер.

**П.Наранбаяр:** Баярлалаа. П.Сайнзориг гишүүний асуултад хариульяа.

Тэгэхээр хүний хөгжлийн индексийг өнөөдөр сайжруулахын тулд бид энэ 3 индекс байгаагийн нэг нь боловсролын салбарт байгаа. Боловсролын индекс. Үүнийг сайжруулахад боловсролын чанар, хүртээмжийн асуудал шууд яригддаг. Хүртээмж нь сайжирч байж чанар дээшилнэ гэдэг нь ойлгомжтой.

Мөн сайн багшийг дэмжиж ажиллуулж байж чанар дээшлэх нь ойлгомжтой. Энэ рүү чиглэсэн иж бүрэн бодлогыг хэрэгжүүлж байгаа.

Хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд ялангуяа боловсролын салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлага зайлшгүй гарч ирж байгаа. Тэгэхээр 2026 оны төсөвт бид жилдээ оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг 900 тэрбумд хүргэхгүй бол болохгүй байна. Энэ тал дээрээ бид Сангийн яамтай ярилцаад явж байна.

Ер нь боловсролын салбар дахь улс төржилтийн асуудлыг ярьсан байна.

Бид ямар нэгэн улс төржсөн тийм томилгоо огт хийгээгүй ээ. Өнөөдөр төрийн өмчийн их дээд сургуулийн бүх ректор нь ажлаа хийгээд явж байгаа. Ер нь энэ салбарт ямар нэгэн байдлаар тийм улс төржүүлсэн томилгоо огт хийгдээгүй.

Ер нь боловсролын салбар өөрөө ийм юмнаас ангид байж байж л зөв бодлого, зөв газартаа, зөв хүн нь байршиж явах учиртай гэж үзэж байгаа.

Бид төрийн мерит тогтолцоо зарчмыг баримталдаг. Энэ юу гэсэн үг вэ гэхээр зэрэг “Үзтэл үнэнээр явагчийг үргэлж өөд нь дэмжигтүн” гэдэг ийм л Монголын өөрийн эртний сургаалаас л их ойр очдог ийм л зүйл.

Тэгэхээр зэрэг хэрвээ таны асуултад бид илүү тоо баримтад түшиж ярих хэрэгтэй бол бид танд бичгээр хариуг өгөхөд бэлэн байна. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Дагуул хоттой холбоотой асуудал. 1 номер.

**И.Батхүү:** П.Сайнзориг гишүүний асуултад хариульяа.

Түрүүн “ногоон хөгжил”, ногоон шилжилттэй холбоотой асуудлууд Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд бүгдэд нь суусан байгаа.

Яг ажиллаж байгаа Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль дээр сая С.Одонтuya сайд мэдээлэл өгсөн.

Хотын хөгжилтэй, ялангуяа дагуул хотуудын хатуу, зөвлөн дэд бүтэцтэй холбоотой асуудлыг 2025 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2.2.6 дугаар бүлэг дээр 12 зорилт, арга хэмжээгээр дэлгэрэнгүй суулгаж өгсөн байгаа. Энэ зорилт, арга хэмжээнүүд маань хариуцсан яамд, орон нутаг хамтраад үйл ажиллагаагаар хэрэгжүүлээд явах юм.

**Ж.Бат-Эрдэнэ:** П.Сайнзориг гишүүн тодруулъяа.

**П.Сайнзориг:** Н.Учрал сайд уг нь хариулах ёстой юм болов уу. Мэдэхгүй байна. Тэгэхдээ яах вэ, одоо би үгээ хэлчихье.

Нийтийн албаны тухай хуулийг оруулж ирнэ гэж байх шиг байна. Үүгээрээ бид хэд энэ асуудлаа бүр нэг цэгцэлчихмээр байна.

Дээрээс нь төрийн болон орон нутгийн өмчийн тэр компанийн асуудлыг зохицуулж байгаа тэр бүтээмжийн хуулийг шийдэхгүй л бол бид хэд энэ зөвлөмжийн байдалтай явдаг дүрэм, журмыг үнэхээр зарим түвшинд биелүүлдэггүй юм байна. Хуулиар л хашигч бол болохгүй нь.

Тэгэхээр энэ асуудлуудаа Засгийн газар ч гэсэн ойлгож байгаа байх. Тэгээд оруулж ирээсэй. Улсын Их Хурал ч гэсэн ажлын хэсэг эрчтэй ажиллаад явчихмаар байна.

Тэгээд И.Батхүү дарга аа, би яах вэ ерөнхий юм авмааргүй байна. Уг нь бол энэ газрын дулаан гээд бас том юм байдаг. Цэвэр эрчим хүчний асуудлууд байгаад байдаг. Үүний хууль эрх зүйн орчин Сэргээгдэх эрчим хүчний хуулиар явах бололц явах бололцоогүй байгаа байхгүй юу.

Оруулаад хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлээд өгвөл хөрөнгө оруулалт байна. Түрүүчээсээ хууль эрх зүйн орчин нь тодорхойгүй мөртлөө газрын гүний дулааныг сургуулиудад, зарим хорооллуудад оруулаад байгаа. Үүнээс үүсэх үр дагавар, цаашдын ашиглалтыг нь хэн хариуцах.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Учрал сайд.

**Н.Учрал:** Төрийн өмчит компанийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хуулийг Их Хуралд өргөн мэдүүлсэн. Энэ хуулийг баталж өгөөч ээ гэж Их Хурлын гишүүдээсээ хүсэж байгаа.

Энэ хууль батлагдсаны дараа төрийн өмчит компани дээр баримтлах чиглэлийг оруулахдаа зоригтойхон шиг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, нээлттэй болгохыг олон улсын зөвлөгөөнүүд хангалттай авлаа л даа. Хийж явъя.

Тэгээд тэр ТУЗ-уудийнхаа шаардлагуудыг хуулиар өсгөж байгаа. Гүйцэтгэх захирлуудын шаардлага өсөж байгаа. Ингээд шаардлага өсөөд өхлэхээр үнэхээр чаддаг, мэддэг, тухайн компанийг авч явахуйц хүмүүс уригдаж төрийн өмчийн компанийг удирдах юм билээ.

Түүнээс биш манай нөгөө сонгуулиуд дээр ажилласан хэд маань хэцүү болно.

Тэгэхээр яг үнэндээ энэ чинь хамтарсан засгийн зовлон байгаа шүү дээ.

**Тийм учраас бид үнэхээр аль болох тухайн албан тушаалд тохирохуй, мэдлэг, ур чадвараараа нийцэхүйц хүн.../минут дуусав/**

**Ж.Бат-Эрдэнэ:** Н.Учрал гишүүн.

**Н.Учрал:** Тийм. Тухайн албан тушаалд тэр бүтээмжийн менежер, хяналтын менежерээр ярилцаж байгаад тухайн тавигдах шаардлагад нийцсэн хүмүүсийг л томилсон.

Тэгээд энэ хүмүүс тийм бүр томилогдчихоод байгаадаа биш. Энэ хүмүүс энэ компанийг илүү ашигтай, илүү бүтээмжтэй ажиллуулахад тодорхой хугацаанд хувь нэмрээ оруулах ёстой.

Түүнээс биш энэ хүмүүс нэг тийм үргэлж тэнд очоод томилогдчихоод байгаа юм байхгүй.

Тийм учраас хуулийг батлагдаад төрийн өмчийн компанийн реформ хэрэгжих хүртэл үнэхээр чадах ажил байвал чадаж хөндлөнгөөс хяналтаа тавьж

ажиллавал үр дүн гарна. Үгүй бол өөрсдийг нь хэмнэнэ гэдэг л ийм л сонголт байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо танилцуулгатай холбоотой үг хэлэх гишүүд. Танилцуулгатай холбоотой үг хэлэх гишүүд. Б.Пүрэвдорж гишүүнээр тасаллаа.

П.Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Би товчхон үг хэлнэ.

Нэгдүгээрт, энэ удаагийн парламент буюу энд сөрөг хүчний үүргийг Үндэсний эвсэл, Иргэний зориг-ногоон нам л гүйцэтгэж байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй.

Бусдууд нь, Монгол Ардын нам, ХҮН нам, Ардчилсан нам засагт хамтарч байгаа гэдгээ ойлгох хэрэгтэй.

Тэгээд зарим нь асуулт асуугаад. Энэ мэтгэлцээн л явж байх шиг байна. Ингэхээр нам руу дайрлаа. Намын сайд нар луу дайрлаа гээд. Энэ сайд нар чинь Ардчилсан намын сайд нар биш шүү дээ. Монгол Улсын сайд нар. Ерөнхий сайд томилчоод байгаа.

Тэгэхээр энэ дээрээ хaa хаанаа бас энэ нэг тийм явган улс төрөө болих хэрэгтэй байх. Тэгээд яах вэ, зүгээр энэ алдаа оноогоо эрт ярилцаж байж л цаашдаа юун дээрээ алдаж байгаа, үүнийгээ дүгнэх байлгүй дээ.

Тэгээд мэдээж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэрхшээлүүд байгаа байх. Зохион байгуулалтын, төсвийн, хүний нөөцийн, хууль эрх зүйн гээд маш олон зүйлүүд байгаа. Энэ дээрээ яг л Монгол Улсын нийтлэг эрх ашиг, хөгжил түргэтгэх тэр эрэмбийн дараалал. Тийм ээ. Тэр зүйлүүдээ тавьж байгаад дэс дараатай бөгөөд оновчтойгоор зарим цөөн ажлуудыг бүр шургуу эрчимжүүлэх гэж ярих уу, маш эрчтэйгээр эрчимжүүлэх ажлыг хиймээр байна. Бүгдийг нь барахгүй. Энэ бол ойлгомжтой.

Тэгэхээр яг хүний хөгжлийн асуудал дээр юуг анхаарах юм, дэд бүтцийн хөгжлийн асуудал дээр юуг анхаарах юм, улсын болон дагуул хотын хөгжил дээр юуг анхаарах юм, эдийн засаг, уул уурхайн салбар дээр юу анхаарах юм гэдэг дээрээ Засгийн газрын гишүүд яг фокуслаасай гэж бодож байна.

Өнөөдөр улсын эдийн засгийн 90 хувь нь уурхайгаас хамаатай мөртлөө уурхайн бодлого нь одоо хүртэл орж ирэхгүй байна шүү дээ. Одоо хүртэл орж ирэхгүй байна. Хэзээ орж ирэх юм бүү мэд.

Өнөөдөр хөрөнгө оруулагчид нь хараад байна. Хувийн хөрөнгө оруулалтууд энэ уул уурхайн салбарт орж ирж болох юм уу гэдэг зүйлүүд нь хараад байна.

Тэгээд энэ чиглэлийнх нь түгжээ болсон Газрын хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, байгаль орчны хуулиудтайгаа балансыг нь олоод уул уурхайн бодлогоо бид тодорхой болгоод зарламаар байна шүү дээ. Хийхгүй байна.

Тэгээд өнөөдөр уул уурхайн бараа, түүхий эдийн үнэ унаж байна. Энэ унаж байгаа дээр бид бодлогоо эрчимжүүлээд дараагийн циклийг эхлэхэд бэлэн баймаар байна. Дараагийн тэр юун дээр. Гэтэл ийм зүйлүүд нь байдаггүй. Эрхэлсэн сайдууд нь байдаггүй. Асуудлаа ярих гээд.

Би С.Одонтуяа сайд байсан гэдгийг хэлмээр юм байна шүү. Зарим сайд нь өрөөндөө сууж байгаад орж ирж хариулдаг юм байна. Ер нь ийм л байдалтай энэ Байнгын хороо, чуулганы хуралдаанд хандаж байна.

Тэгэхээр ийм зүйлүүд байна. Тэгээд энд нэг их хүний мууг үзэх гээд байгаа юм биш. Танай манай гэж ялгаад чимхэж аваад чиглээд байгаа юм алга. Энэ дээрээ хэдүүлээ нэг ойлголцихьё.

Тэгээд одоо ингээд үг хэлэхээр л Ардчилсан намын сайдуудыг барьж авна гээд зарим хүмүүс хэдэн бүсгүйчүүдийг барьж аваад янз янзаар хэлээд байх юм. Одоо Б.Пүрэвдорж гишүүн шүү дээ. Би хэлчихье. Тэгээд ёс бус үг хэлж байна. “П” гэдэг үгийг нь харамгүй хэлдэг хүн байна.

Тэгэхээр хэдүүлээ улс төржвэл адилхан улс төржиж чадна шүү дээ. Аль болохоор ойлголцоод, ийм зүйлүүд байхад зөвхөн манай танай руу дайрлаа гээд байх юм.

Тэгэхээр үүндээ хаана хаанаа байя. Тэгээд энэ төрийн албан хаагчдыг ажлыг нь хийлгэе. Сайд нар нь ирдэг байя. Ядаж энэ дээр Төрийн нарийн бичгийн даргаас дээшээ хүмүүс нь ирнэ. Бусад нь ажлаа хийж байя. Ялангуяа яах вэ ерөнхий чиг үүргийн бодлогын гэдэг юм уу, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам ч байдаг юм уу ийм чиглэлийн яах аргагүй бодлогын дарга нар ирж болж байна. Газрын дарга. Бусад нь ажлаа хийж баймаар байна шүү дээ.

Тэгээд энд нэг ч бодлогын асуултад хариулах хүн алга. Тэгээд дараа нь бүгд мэдэхгүй. Тэгээд ийм байдалтай сайд нар чинь байна шүү. Ялангуяа Ерөнхий сайдыг орлох хэмжээний гурван Шадар сайдын нэг нь ч үзэгдсэнгүй. Ядаж Эдийн засаг, хөгжлийн яамных нь Шадар сайд энэ дээр суугаад.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Батбаатар гишүүн үгээ хэлнэ.

**Б.Батбаатар:** Өнөөдөр бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тайлангийн асуудлаар ярьж байна.

Засгийн газар өөрөө хэрэгжилтийг нь гуравны нэг хувийн биелэлттэй байна гэж үнэлж, дүгнэж байна. Их Хурал болохоор дөрөвний нэг гэдгээр нь үнэлж дүгнэж байна. Энэ чинь их хол зөрүүтэй тоо шүү дээ. Гуравны нэг, дөрөвний нэг гэдэг чинь. Аргачлалт тоон дээрээ зөрүү гарцаад байна гэдэг юмыг Н.Учрал сайд сая хэлж байна лээ.

Яг үнэндээ Засгийн газрын бүх суурь алдаа, өнөөдрийн бүх үүсээд байгаа нөхцөл байдал Улсын Их Хурлын үнэмлэхүй олонх буюу 118-ын бүдүүн бүлэг байгуулсандаа л байгаа шүү дээ. 118-ын Их Хурлын гишүүнтэй Засгийн газар гэдэг чинь юуг ч дураараа хийж байгаа байхгүй юу.

Цааш цаашдаа Иргэний Зориг-Ногоон Нам бол эхний 6 сар тогтвортой хүлээцтэй харсан. Дөнгөж засаг байгуулагдаад 6 сар болоход юм болгон дээр нь ямар нэг байдлаар сөрөөд байх гэдэг утгаар нь хандаад байх нь буруу юм гэж үзсэн. Алтернатив санал буюу өөр хувилбарууд, илүү сайн хувилбаруудыг санал болгож ажиллана гэж бид бодож байгаа. Тэгж ч төлөвлөж байна.

Дээрээс нь хүний эрх чөлөө, дээрээс нь эрх мэдлийн хязгааргүй олголт, тэрийг дагасан хөрөнгө санхүүгийн замбараагүй урсгал, энэ бүхэн тоймоо алдаж эхэллээ.

Бид юу гэж ойлгож, бодож байна вэ гэхээр тэрийн албан хаагч, яам, тамга, агентлагийн удирдлагууд, сайд нар, энэ бүх хүмүүсийн алдаатай буюу буруу үйлдэл дээр нь бид энэ засгаасаа чөлөөл гэдэг зүйлийг Ерөнхий сайдад санал хүргүүлнэ. Цаашид.

Хэрвээ Ерөнхий сайд нь үнэхээр алдаа дутагдал гаргачихсан, болохгүй байгаа, хүний эрхийн чиглэлд асуудал болгож байгаа, эдийн засаг, улс орны нөхцөл байдал, Монгол Улсын иргэдийг сайхан амьдрахад нь садаа болж байгаа тэрийн албан хаагчийг чөлөөлөхгүй бол Ерөнхий сайдыг өөрийг нь огцор гэдэг асуудлыг цаашаа тавих болно. Ингэж ажиллах нь Иргэний Зориг-Ногоон Намын хувьд зөв юм байна гэдэг ийм байдлаар бид хандаж байгаа.

Тийм болохоор үйл ажиллагаагаа явуулаад энэ Засгийн газар хагас жил боллоо. Тайланг хэлэлцэхэд өнөөдөр ийм зөрүүтэй нөхцөл байдалд, ийм улс төржсөн нөхцөл байдалд бүгдээрээ алга ташиж хүлээж авах нэг ширхэг ч алга ташилт байхгүй ийм нөхцөл байдалд бид хэлэлцээд сууж байна гэдэг чинь Засгийн газрын ажил санаснаар явахгүй байна гэсэн үг.

Үндсэндээ Их Хурлын 126 гишүүн бараг 100 хувиар, 118-ын бүлэг тэр чигээрээ Засгийн газрын үйл ажиллагааг дэмжиж хагас жил өнгөрлөө шүү дээ.

Цааш цаашдаа энэ сайд нар, төрийн ажил үүрэг хариуцсан хүмүүс ажилдаа хариуцлагатай хандах. Эд нартаа хариуцлага тооцож, үүрэг даалгаврыг нь өгч байх ёстой Ерөнхий сайд нь хариуцлагатай хандаж ажиллах энэ зүйлээ бodoх хэрэгтэй.

Одоо энэ хэлэлцэгдэж байгаа тайланг тийм сайхан тайлан болчихлоо, гүйцэтгэл нь, дүгнэлт нь үнэхээр зөв байна гэж хэлэх арга алга байна. Тэгээд нэгэнт хаврын чуулган эхэлсэн.

Тийм болохоор цааш цаашдаа энэ дээр анхаарах хэрэгтэй. Улсын Их Хурал өөрөө Засгийн газар биш ард түмний төлөөлөл гэдэг тал дээрээ Их Хурал маань бодож баймаар байгаа юм. Засагтай адилхан Улсын Их Хурал дээр байдаг хяналт шалгалтын чиг үүрэг бүхий бүх бүтцүүд нь засаг бүрдүүлж байгаа 118 дотроо багтаад орчихсон. Яаж ташуурдах юм энэ Засгийн газрыг, яаж хянах юм. Ямар ч боломжгүй зүйл шүү дээ. Үүнийг дахин дахин сануулж хэлж байгаа. Энэ чиглэлээр ч гэсэн Их Хурлын.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Э.Болормаа гишүүн үгээ хэлье.

**Э.Болормаа:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе.

Тайлан дээр ажилласан тус тусын байгууллагуудад баярлалаа. Өнөөдөр тайлангийн зөрүүтэй зүйлийг хэлээд байх шиг байна. Тэгэхдээ энэ бол бид нарын нэг их эмзэглэх зүйл огт биш гэж харж байгаа юм. Аудитын газраас тайлан гарна, Их Хурлаас тайлан гарна, Засгаас тайлан гарна. Ер нь аргачлалын зөрүүнүүд байгаа.

Энэ дундаас Улсын Хурлын Тамгын газрын зүгээс энэ аргачлалыг нэлээн шинэчилж, олон улсын байгууллагын түвшинд хүргэх гэж, үр дүнд суурилсан байлгах гэж өөрчлөлт орсныг нэлээн анзаарсан.

Би энэ дээр илүү Засгийн газрын сайд нартаа нэг зүйлийг онцолж хэлмээр байгаа нь юу вэ гэхээр бид Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний тухай хуулиараа ганц урт хугацааны хөгжлийн бодлоготой байна гээд хуульчилсан. Тэр маань 2050 оны “Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг.

Харин дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдээ хийх ёстой. Миний хувьд үүний эдийн засгийн хэсгийг нь болох “Шинэ сэргэлт”-ийн бодлогыг тухайн үедээ ахалж боловсруулж байсан. Гэхдээ үүнээс гадна хүний хөгжлийн зорилтот хөтөлбэр, нийгмийн хөгжлийн, байгаль орчны, засаглалын, бусийн хөгжлийн, үндэсний өрсөлдөх чадварын, шинжлэх ухаан, технологийн гээд тус тусын зорилтот хөтөлбөрүүд хийгдэх ёстой.

Тэгэхээр энэ дээрээ анхаарч. Бид дараа нь зүгээр тайлан хэлэлцэх биш яагаад үр дүнд хүрч байна, яагаад хүрэхгүй байна гэхэд миний эндээс анзаарч байгаагаар яг ийм зорилтот фокусласан хөтөлбөр байхгүй байна гэдгийг нь анхаарч байна.

Экспорт нэмэгдсэн гэдэг зүйл бол үнэхээр 2021 оны эцэст Их Хурал баталсан “Шинэ сэргэлт”-ийн бодлогын үр дүнд 4 жилийн хугацаанд экспорт бараг 2 дахин нэмэгдсэн. Яг бид зорилтот хөтөлбөрөө гаргаад, фокуслаад энэ ажлыг хийе гээд нэгдсэн бодлого, төлөвлөгөө гаргахад тодорхой хэмжээний үр дүнгүүд гарч байна.

Харин энэ уялдсан бодлогогүй, Засгийг газрын Хэрэг эрхлэх газар дээр энэ бодлогууд, зорилтот хөтөлбөрүүд бүгдээрээ нэгтгэх байх. Эд нарыгаа дэс дараалалтай яаралтай оруулж ирээч гэж Засгийн газрын зүгээс хүсмээр байна.

Харин тайлангийн зүгээс бид тайлан хэлэлцлээ гээд ер нь энэ хандлагын асуудал байна. Хэдэн гишүүд орж ирээд төрийн албан хаагчдыг юу юугүй загнаад байх ёс зүйн хувьд ч боломгүйгүй асуудал, ажлын үр дүнгийн хувьд ч гэсэн хэн ч загнуулаад ажлаа сайхан хийе гэдэг тийм мэдрэмж төрөхгүй.

Би П.Сайнзориг гишүүнтэй санал нэг байна. Ер нь Байнгын хороонд энэ асуудлаа танилцуулах үүрэгтэй. Ялангуяа ийм томоохон тайлангийн шинж чанартай зүйлс яг сайд нарын өөрсдийн үүрэг хариуцлага.

Түүнээс доош магадгүй Төрийн нарийн. Тэгээд бусад хүмүүс ажлаа хийж байх ёстой. Энд ирээд мешок шиг хүмүүст янз бүрийн хэрэгтэй хэрэггүй юмнууд загнуулаад, ийм үнэн худал юман дээр ийм байдалд бид гишүүд ч гэсэн энэ асуудал дээр анхаарч цаашдын ёс зүйн асуудал дээр манай Байнгын хорооны дарга анхаарч өгөөч гэж хүсье. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Ёс зүйн талаас нь харья харья. Тэгэхдээ нэг их загнаад байгаа юм байхгүй шүү дээ. Хариуцлагын асуудал л яригдаж байгаа шүү дээ. Тийм.

**Ж.Бат-Эрдэнэ:** Р.Батболд гишүүн.

**Р.Батболд:** Өдрийн мэнд хүргэе. Та бүхэндээ.

Бид чинь нөгөө хөгийн юм хийж байна гэдэг шиг гурван өөр гүйцэтгэлийн хувьтай тайлан яриад байсан.

Өнөөдөр явж явж Үндэсний аудитын газрынхаа тайлангаар л явчих шиг боллоо. Одоо нөгөө 67.7 хувийн хэрэгжилттэй тайлангаараа яваад байна л даа.

Тэгээд ер нь нэг л асуудал байгаад байна. Бид 5 жилийн төлөвлөгөө хийгээд байдаг. Гүйцэтгэл маань 67 хувьтай гарчхаад байдаг. Одоо хэнд хариуцлага тооцох юм гэдэг асуудал. Хэн хариуцлага хүлээх юм бэ гэдэг. Ямар ч хариуцлагагүй. Бид төлөвлөөд л байдаг. Дараа нь үүнийгээ тэдэн хувьтай л юм байна шүү дээ. Зарим нь хэрэгжээгүй. Энэ чинь 60, 70, 150-иараа огт хэрэгжээгүй ийм асуудлууд байгаад байдаг.

Тэгэхээр төлөвлөлтдөө алдаа байгаад байгаа юм уу, хэндээ алдаа байгаа юм. Хариуцлагаа ер нь хэнтэй тооцох юм. Бид. Үүнийг ер нь юу гэж харах юм гэдэг л асуудал байна.

Одоо энэ 5 жилийн төлөвлөгөөг хийхдээ бид сонгуулийн жил давуулж биш, сонгуулийн жилийн өмнө дүгнэдэг байдлаар хийвэл бид нарт арай бас нэг ажил хийхэд дөхөмтэй болох юм уу гэж хараад байна. Одоо бид 2028 он биш энэ 2027 онд дүгнэхээр хийвэл ажил явах нь арай дээр юм уу л гэж харагдаад байна. Өөр ч нэг их айхтар санал хэлээд байх ч юм алга.

Тэгээд уг нь нэг аргачлалаар хийгээд байдаг. Энэ тайлан чинь тэгээд гурав зөрчөөд л байгаа. Үүнийгээ яаж нийлүүлэх юм бэ. Манай хяналт тавьж байгаа газрууд маань үүнийгээ нэг шийдэхгүй бол болохгүй байх. Энэ дээр Их Хурлын гишүүд дунд гурван өөр юм оруулж ирчхээд яриад байдаг. Ийм л санал байна даа.

**Ж.Бат-Эрдэнэ:** О.Алтангэрэл гишүүн.

**О.Алтангэрэл:** Би түрүүний О.Номинчимэг гишүүний асуулттай холбоотойгоор хариулах цаг олдоогүй учраас үг авсан юм. Буруу ойлголт төрчих гээд байна л даа.

Монгол Улс авлигын индексээр урагшилсан гээд ярьсан. Худлаа ярьж байна, худлаа ярилаа гэдэг асуудал тавилаа. Тэгээд хүмүүс тэгээд буруугаар бодоод үлдчих вий.

Дараа нь Б.Мөнхсоёл гишүүн хүртэл тэр үгийг нь О.Номинчимэг гишүүн хэлсэн учраас хүлээж аваад ер нь ийм байна гээд дурдаж байгаа юм. Тэгэхээр хүмүүс үзээд нээрээ ингээчихсэн юм байна гэж бодох байх.

Монгол Улс 2024 онд Transparency International-ийн авлигын индексийн үзүүлэлтээр 7 байр урагшилсан. Би түрүүн 5 гэж харин ч дутуу хэлсэн байна. 7 байр.

Тэгэхдээ энэ нь их гавьяя байгуулаад л авлигын индекс буураад байна гэдгээрээ биш. 2024 онд гэхэд жишээлбэл Battlemériйн Энхбаяр сайд бид 2 энэ 2024 онд ажил үүрэг зэрэг гүйцэтгэж байсан. Тэгээд гарч байгаа л үр дүн. Хамгийн гол нь энэ мэдээлэлдээ бодитой байгаасай, буруутгалаа бодитой

хэлээсэй. Ард түмэн үзэж байгаа, харж байгаа энэ зүйл дээрээ нэлээн судалгаатай яриасай гэж хүсэж энэ мэдээллийг өгсөн юм. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Мөнхсоёл гишүүн.

**Б.Мөнхсоёл:** Бэлдээгүй тоо О.Алтангэрэл сайд дурдчихлаа гэдэг шиг.

Энэ авсан оноо нь чухал байдаг юм. О.Алтангэрэл сайд аа. Гарчиг жишээлбэл ингэж явж байна. Монгол Улс авлигын индексээр 180 орноос 114 дүгээрт жагсаж, ардчилсан бус засаглалтай орнуудын тоонд дахин багтлаа гэнэ ээ. Аливаа олон улсын тайлан, зэрэглэл, жагсаалтад ороход аргачлал маш чухал байдаг.

Ийм учраас үнэлгээн дээр ч гэсэн өнөөдөр аргачлал маш их ярьж байна. Адилхан асуудал.

2023 онд 33 оноо авч байсан. 2024 онд бас 33 оноо авсан байна шүү. Өөрөөр хэлбэл чанарын ялгаа гараагүй. Зүгээр жагссан орны тоонд өөрчлөлт орох ч юм уу, бусад орнууд илүү дэвшилтэт юм хийсэн учраас. Тийм. Би яах вэ ухаж өгч байна.

Энэ чинь тооны ард утга явах ёстой. Үгүй үгүй. О.Алтангэрэл сайд аа, чи мэдэж байгаа боловчиг өөрийн чинь хэлснээр ард түмэн харж байгаа гэдэг дээр нэмж тайлбар өгөхгүй бол тоо яагаад ярьдаг вэ. Тоо утга илэрхийлдэг учраас. Утгыг дандаа давхар ярихгүй бол хүн буруу ойлгох шүү дээ. Энэ чинь түгээмэл асуудал шүү дээ.

Тэгээд гол юм руугаа орьё. Үг хэлсэн гол санаа юу вэ гэхээр түрүүн би чанарын судалгааны тухай асуусан. Тодорхой хариулт ирээгүй шүү дээ.

Тэгэхээр яг саяын зүйлтэй холбоотой бид өнөөдөр яагаад нэг юман дээр эргэлт нь тойроод бүх гишүүд төстэйдүү асуулт асуугаад хариултууд төстэйдүү байна гэхээр нэгдүгээрт аргачлал үнэхээр сул байна. Чанарын судалгаа хийсэн, үгүйгээ ч мэдэхгүй байна. Яагаад тэдээс тэдэд орчихсон юм. Асуудал юунд байв. Цаашдаа юу хийх гээд байгаа вэ гэдгээ уг нь хариулаад явчихвал гишүүд давтан давтан нэг юмыг олон янзаар нь асуугаад байхгүй байх.

Тийм учраас би энэ мэргэжилтнүүд, экспертуудийг уг нь үнэлж хүндэлдэг. Тэгээд бэлдэж орж ирээсэй. Ажилдаа чанартай хандаасай л гэж ийм л үгийг хэлмээр байгаа юм.

Тэгээд аливаа үнэлгээ аргачлалтай байдаг шүү. Аргачлалаа өөрсдөө дээр дооргүй маш сайн ойлгоод, төлөвлөх тооцоходоо анхаараад хэрхэн яаж. Тэр хэлээд байна шүү дээ. Н.Учрал сайд хэлсэн шүү дээ. Та өөрөө сая. Тэдэн оноондоо хүрсэн учраас тавьсан зорилтдоо 70 гэсэн бол 70-ынхаа 65-д

хүрчихсэн учраас сайн гээд дүгнээд байгаа юм. Тэдэн хувь гээд. Гэтэл начир дээрээ, бодит амьдрал дээр авлига шийдэгдсэн гэсэн үг биш гээд.

Наадхаа сайн яриад тэгээд 70 гэдэг чинь ямар учиртай юм. 70-д яаж хүрэх юм. Хүрээгүй яагаад гэдгээ хариулахгүй бол тоо хаяад л, тоо хаяад байхаар чинь танд ч муу, иргэдэд ч муу, бид нар гишүүдэд ч муу. Энэ чинь зөрчил үүсгээд байна шүү дээ. Байгаа зөрчил дээр нэмэх зөрчил. Энэ дээрээ л анхаарчих гээд. Нэгэнт бүгдээрээ адилхан л Монгол Улсын иргэд. Ямар ч албан тушаалтай байсан Монгол Улсын хөгжлийн төлөө санаа зовоод байгаа юм байгаа биз дээ. Түүний төлөө бид ажиллаад байгаа шүү дээ.

Тэгэхээр санаа зовоод хэлээд байгаа юм шүү. Түүнээс хүн ялахын төлөө би гишүүн болсон гэж ерөөсөө боддоггүй. Баярлалаа.

**Ж.Бат-Эрдэнэ:** С.Бямбацогт гишүүн алга байна. Г.Уянгахишиг гишүүн.

**Г.Уянгахишиг:** Ер нь яг энэ үнэлгээний тайлангуудыг, 3 тайлан хэлэлцэж байна шүү дээ.

Тэгэхээр яг энэ Засгийн газраас гарсан, Их Хурлаас гарсан, Үндэсний Аудитаас гарсан энэ үнэлгээнүүдээс харахаар бид одоо яах вэ, яг энэ чинь яагаад ингэвчихсэн юм, эсвэл аягүй муу байна ч гэдэг юм уу энэ талаасаа харахаас илүүтэйгээр үүнийг засаж сайжруулах боломж нь юу байна вэ. 2025 оны гүйцэтгэлийн үнэлгээ илүү сайжирч гарахын тулд бид юугаа засах ёстой юм бэ гэдгээ ярилцах ёстой байх гэж харж байна.

Үүнтэй холбоотойгоор яг гурван зүйл хэлмээр байгаа юм.

Нэгдүгээрт, мэдээж сая яригдаж байна. Хэмжигдэхүйц үзүүлэлт байх ёстой. Тийм ээ. Ер нь Ки Пи Ай тооцож байгаа тохиолдолд тэр өөрөө хэмжигдэхүйц байх ёстой, хүрэхүйц байх ёстой, зорилтот түвшинтэй чинь уялдаж байх ёстой.

Үүнийгээ бид ямар ч байсан засах ёстой юм байна. Үүнийгээ гаргахын тулд хэрвээ хууль эрх зүйн орчин нь өөрөө тийм зөв биш байгаа бол энэ талаасаа Засгийн газраас засаж сайжруулах өөрчлөлтүүдийнхээ саналыг оруулж ирээч ээ. Цааш цаашдаа хэдүүлээ иймэрхүү байдлаар тоон дээрээ будилаад яваад баймааргүй байна.

Хоёрдугаарт, одоо яг энэ хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүд дээр аягүй сайн анхаарах хэрэгтэй байна гэж харагдаад байна. Одоо энэ хүснэгт 10 дээр байна л даа. Төсөл, арга хэмжээний санхүүжилт эх үүсвэр гээд. Энэ дээрээс харах юм бол бид 13.9 их наядын төсөв төлөвчхөөд эндээс 5 их наядыг л зарцуулсан байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол энэ санхүүжилт чинь өөрөө 50 хувьдаа ч хүрэхгүй. Хэдхэн хувьтай. 30, 40-хөн хувьтай. Тийм үү.

Тэгэхээр яаж нөгөө төсөл, хөтөлбөрүүд чинь хэрэгжих юм бэ. Эндээс хархаар төсөв даваад бэлдсэн байгаа юм. Өөрөөр хэлбэл яг төсвөөр төсөл, арга хэмжээ нь 120 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх байтал 61 төсөл, арга хэмжээ буюу 50 хувьтай. Гэтэл нөгөө зарцуулсан мөнгө чинь 2.2 их наядаас 2.6 их наядыг зарцуулчихсан байгаа байхгүй юу.

Тэгэхээр төсөв хэтэрчихсэн харагдаад байгаа юм. Гэтэл нөгөө талаас төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4.5 их наядыг зарцуулна гэж байна. Гэтэл энэ дээр 160-хан тэрбумын зарцуулалттай. Эндээс хархаар энэ санхүүжилтээр хийнэ гэсэн төсөл, хөтөлбөрүүд чинь яаж хэрэгжих юм. Боломж байхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ хоёр дахь анхаарах зүйл бол ерөөсөө энэ хөрөнгө оруулалтын төсвөөс бусад эх үүсвэрүүдийгээ хэрхэн яаж зарцуулах юм. Үүний садаа болоод байгаа учир шалтгаанууд нь юу юм бэ. Энэ дээр жишээлбэл яг тэр эх үүсвэрүүдийг татаж оруулж ирэхэд гаднын дотоодын эх үүсвэр, хувь төр, хувийн түншлэлийг сайжруулахад эрх зүйн орчин чинь болохгүй байгаа юу уу, эсвэл яг үүнийг хэрэгжүүлэх дээр бодит байдал дээр юу садаа болоод байгаа юм. Үүнийгээ бас ярилцмаар байна. Үүнийгээ засаж сайжруулмаар байна.

Гуравдугаар асуудал гэх юм бол хариуцлага. Өөрөөр хэлэх юм бол хэрвээ бид гүйцэтгэлийн үнэлгээ ярьж байгаа бол, Ки Пи Ай ярьж байгаа бол энэ үнэлгээ өөрөө хангагдаагүй тохиолдолд, гүйцэтгэл дутуу үнэлэгдсэн тохиолдолд хэн ямар хариуцлага хүлээх юм бэ гэдэг тодорхой байж үнэлгээгээ гаргах төлөвлөлт чинь өөрөө хүрэхүйц байдлаар хийгддэг. Хийж чадахуйц ажлаа төлөвлөдөг. Энэ төлөвлөгөөнд хүрэхийн төлөө юу хийх хэрэгтэй байна вэ гэдэг дээрээ анхаарал хандуулж ажилладаг.

Гэтэл үүний цаана төлөвлөгөө, буцаад гүйцэтгэл хоёр ийм хэмжээний юу гэдэг юм 40 хувьтай, 50 хувьдаа хүрэхгүй байж байхад үүний цаана яг хэн хариуцлага хүлээх вэ гэдэг нь тодорхойгүй байгаад байхаар анхны төлөвлөгөө дээр ч анхааралгүй байна, гүйцэтгэл дээр ч гэсэн буцаж явцын дунд бүтэн жилийн хувцас хугацаанд яг энэ гүйцэтгэл унах гээд байна гэдэг дээр анхаарч засаж сайжруулах ажлууд хийгдсэн үү гэдэг асуудал байна.

Яах вэ, 2024 оны хувьд сонгуультай жил байсан. Солигдсон гэдэг утгаараа асуудал үүссэн байх.

Гэхдээ бид 2025 оны.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Ц.Сандаг-Очир гишүүн үгээ хэлье.

**Ц.Сандаг-Очир:** Их Хурал Засгийн газрын бодлогын хөгжлийн төлөвлөгөөнүүдийг баталж өгдөг. Тэгээд Засгийн газар Их Хуралд эргүүлээд

хөгжлийн төлөвлөгөөнүүдийн биелэлтийг тайлагнаж байгаа л нэг хэлбэр шүү дээ. Цаасан дээр.

Тэгээд гишүүдийн бухимдаад байгаа асуудлууд бол нэгд үнэлгээний аргачлал уялдаагүй байна, ялгаатай байна гэж ярьж байна.

Хоёрт, цаасан дээр байгаа үнэлгээ, дүгнэлт, журам бодит амьдрал дээр нийцэхгүй байна гэдэг асуудлыг л ярьж байгаа шүү дээ. Цаасан дээр бид хэн хэнийгээ аргалаад гэдэг юм уу, сайн байна, мундаг байна, өндөр хувьтай байна гээд дүгнэж болно.

Эцсийн эцэст 4 жилийн, 5 жилийн, тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнүүдийн үр дүн ард түмний амьдралаар л хэмжигдэх ёстай. Айл өрхийн амьжиргааны түвшин үнэлэх ёстай үнэлэгдэх ёстай. Засгийн газар чинь ард иргэдийнхээ амьдрал ахуй, улс орныхоо эдийн засгийг л өөд нь татах гэж л ажиллаж байгаа юм байгаа биз дээ. Тэрний эцсийн үр дүн ямар байгаа юм бэ гэдгийг л бид яриад байна шүү дээ.

Тэгэхээр цаасан дээр дүгнэлт гаргаж байгаа биелэлт, бодит амьдрал дээр ард иргэдийн амьдрал, эдийн засгийн нөхцөл байдал, айл өрхийн амьдрал ахуй ямар байна вэ гэдэг асуудлыг л яриад байна шүү дээ.

Тэгэхээр бодит байдалдаа нийцэхгүй зүйлүүд олон байна. 100 хувь ч гэдэг юм уу, 70, 80 хувьтай байгаа асуудлууд. Гэхдээ Засгийн газар өнгөрсөн хугацаанд огт ажил хийгээгүй гэвэл бодит үнэнээс хол зөрөх байх. Үнэхээр сайн ажиллаж байгаа гэвэл бүр ч хол зөрөх байх. Бодит байдлаас.

Тийм учраас асуудалд авах гээхийн ухаанаар. Тэгээд энд байж байгаа төрийн албан хаагч нар Засгийн газар, Их Хурлаас баталж өгсөн энэ аргачлал журмын дагуу л тайлан юмаа гаргаж байгаа шүү дээ. Энд байгаа төрийн албан хаагч нар луу дайрч давшилаад, уурлаж унтууцаад байх юм өрөөсөө байхгүй.

Үүнийг чинь маш олон хоногийн хугацаанд, маш олон төрийн албан хаагч нар, төрийн дунд, анхан шатад өчнөөн юм болж байж энэ тайланг гаргадаг юм л даа. Тэгээд төрийн албанд ажилласан улсууд гадарлах байх. Ажиллаж байгаагүй гишүүд тэр болгон сайн мэдэхгүй байх.

Тэгэхээр энэ гаргасан тайланг бодит амьдралтай хэр нийцэж байна вэ гэдгээр л би Засгийн газрын ажлыг дүгнэх л юм болов уу л гэж бодож байна.

Тэгээд эцсийн эцэст үр дүн сонгуулиар шүү дээ. Ард түмэн энэ Засгийн газрыг яаж үнэлж дүгнэж байна вэ. Энэ 4 жилийн хугацаанд Засгийн газрын хийж хэрэгжүүлсэн ажил ямар үр дүнд хүрэв, ямар ахиц өөрчлөлт гарав гээд.

Тийм учраас энэ бол нэг их шинэ ажил биш. Цоо шинэ ажил хийгээд л гэв гэнэтхэн энэ жил нэг дүгнээд байгаа юм шиг юм биш шүү дээ. Жил болгон л яригддаг асуудал шүү дээ. Харамсалтай нь бид Их Хурал, Засгийн газар энэ аудитын гаргасан дүгнэлтийг ерөөсөө ач холбогдол өгдөггүй байхгүй юу. Гаргаж байгаа зөвлөмжүүдэд ерөөсөө ач холбогдол өгдөггүй. Төсөв дээр мөн адилхан. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт гаргадаг, зөвлөмж гаргадаг, аудит дүгнэлт зөвлөмж гаргадаг. Хэн ч авч хэлэлцдэггүй. Ингэсээр байгаад л өнөөдрийг хүрсэн.

Цаашдаа хэлэх зүйл бол эндээс бид жилийн хөгжлийн төлөвлөгөөг нь баталж өгч байгаа юм бол энэ үг, өгүүлбэр, заалт болгоны цаана төсөв мөнгөтэй холбоотой асуудал байдаг. Явж явж төсөв дээр л тогтдог юм шүү дээ. Тулдаг шүү дээ. Асуудлууд.

Тэгээд Их Хурал баталж өгөхдөө холбогдох төсвүүдийг нь баталж өгдөггүй юм. Баахан төсөвгүй ажлууд хийнэ гээд баталчихдаг юм. Тэгээд энэ биелэлт нь хэрэгжихгүй байгаагийн учир шалтгаан нь ерөөсөө энэ шүү дээ.

Тэгээд яг нөгөө төсөв батлах, жилийн эцэст, оны эцэст хөрөнгө оруулалт, төсөв батлах болохоороо гишүүд өөрсдөө баахан тойргийн асуудлаа баталчихдаг. Яг энэ нөгөө хөгжлийн төлөвлөгөөнд орсон бодлогын асуудлуудаа.../минут дуусав/

**Ж.Бат-Эрдэнэ:** Ө.Шижир гишүүн.

**Ө.Шижир:** 1990 оноос хойш одоогийн байгаа Засгийн газар бол 17 дахь Засгийн газар. Тэгээд 2017 онд Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд нийтдээ 597 ширхэг хөгжлийн ямар нэгэн хөтөлбөр баталсан юм билээ.

Тэгээд түүнээс яг одоогоор 68 нь хүчингүй, 204-ийнх нь хугацаа нь дууссан. Бусад нь хүчин төгөлдөр явж байгаа.

Тэгээд энэ өөрөө юуг хэлээд байна вэ гэхээр үндсэндээ бид нэг тоозогносон шинжтэй цаас хийдэг. Тэр цаасыг нь дагаж баахан төрийн байгууллагууд 30, 40-үүлээ сууж дүгнэлт хийдэг.

Тэгээд тэр дүгнэлт нь хоорондоо зөрдөг ийм л асуудал л даа. Яг адилхан Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор үнэлэлт, хяналт үнэлгээ хийсэн Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтэс чиглэлийн яам хоёрынх нь үнэлгээ нь хоорондоо зөрчихсөн.

Яг нэг цаасан дээр л дүгнэлт хийж байгаа шүү дээ. Зөрж боллоо гэхэд тэгж 10, 15, 20 хувийн зөрүүтэй зөрж байгааг нэгдүгээрт ойлгохгүй байна. Нэг бол Засгийн газрын тогтоол, хуулиа хоёр өөрөөр уншаад байна гэсэн үг.

Ер нь Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээгээ хийгээд, чиглэлийн яам нь хяналт үнэлгээгээ хийгээд, аудитын дүгнэлтээ гаргах болгох юм дээр бүгдээрээ дүгнэлт хийгээд, бүгдээрээ шинжилгээгээ, бүгдээрээ хяналт хийчихсэн. Ийм л байдал үүсэж байна.

Энэ чинь өөрөө ер нь ойлгомжгүй байдлыг бий болгож байгаа юм. Их Хурлын гишүүдийн хэлээд байгаа зөв шүү дээ.

Яагаад өөр өөрөөр дүгнээд байгаа юм бэ гээд. Ер нь яах вэ бид төлөвлөгөө, төсөл, аливаа урт хугацааны хөтөлбөрийг батлахдаа сэтгэл хөөрлөөр баталдаг чинь ингээд харагдаж байгаа гэсэн үг. Бодит байдалтай нийцэхгүйгээр баталж байна гэсэн үг. Хүрэх үр дүнгээ зөв тооцохгүй байна гэсэн үг.

Тийм учраас бид энэ зүйл үүсээд байгаа юм. Нөгөө талаасаа хуулийн зөрчилтэй маш их байна. Жишээ нь, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 12.1, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 20.1 гээд. Хоорондын зөрчилтэй. Дүгнэлтийн хугацаанууд өөр өөрөөр заачихсан. Түүний чинь үр дүн өрөөсөө энэ л дээ.

Яах вэ, зүгээр цаас үйлдвэрлээд хэдүүлээ үүнийг хэлэлцсэн болоод, манай ажлын хэсгийнхэн минут хурдан дуусаасай гээд, Их Хурлын гишүүд нь асуусан болоод дуусаж болж байна. Тэгээд энэ ямар үр дүнтэй байх юм бүү мэд.

Одоо жишээ нь:

- ▷ Эрүүл мэндийн яаман дээр дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ. 100 хувь гэчихсэн байгаа.
- ▷ Тэгээд бид дотоодод олон улсын стандартад нийцсэн тийм сайн эм хэрэглээд байгаа юм уу гэхээр үгүй шүү дээ. Үүнийг зүгээр захыг нь та нар аптект үйлчилгээ үзүүлж байгаа хэрэглэгчээс асуугаад үзээрэй.
- ▷ Мянган хүнд ногдох явган хүний замыг 100 хувь хүргэнэ гэчихсэн. Энэ байхгүй. Тэгээд 100 хувь гээд дүгнээд гаргаад ирчихсэн.
- ▷ Авто замын уулзварын нэвтрүүлэх чадварыг 100 хувь гээд дүгнээд гаргаад ирчихсэн.
- ▷ Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын хөрөнгийн өгөөжийг 100 хувь гээд ингээд дүгнэчихсэн. Гэтэл 2024 оны аудитын тайлан дээр 5-хан төрийн өмчит компани чинь ашигтай ажилласан ажилласан шүү дээ. Тэгээд энэ 100 хувь өдийд дүгнэлт чинь яг бодит амьдралтайгаа нийцэхгүй. Ингээд бид өөр өөр л юм хийгээд байна гэсэн үг л дээ.

Тэгэхээр одоо энэ Хяналт шалгалтын яам, Улсын Их Хурлын Тамгын газар Хяналт шинжилгээний хэлтэс журмаа хоёр өөр болгодог юм уу, аль эсвэл нэг болгодог юм уу. Ингээд явахгүй бол энэ чинь дахиад ирэх жил болж ирнэ.

Энэ аудитын дүгнэлт дээр ганц зөв дүгнэлт байна лээ. Тэрийг би та нарт уншиж өгье.

Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах, Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах, тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгсэл нь үр дүнд хүрээгүй буюу 0 хувь байна гэж. Үүнийг харин ёстой зөв дүгнэсэн юм байна лээ. 0 хувь гэж. Бусад нь бүгдээрээ худлаа.

Тэгэхээр энэ олон дүгнэлт, энэ олон юунуудаа нэг болгоод явахгүй бол цаашдаа хоёр өөр цаас харж, хоёр өөр утга хэлбэр илэрхийлээд Их Хурлын гишүүд чинь хоорондоо хэрэлдээд сууж байна шүү дээ. Сүүлдээ чи, би, танай, манай. Танай, манай сайд гээд. Энэ чинь ерөөсөө улс төржиж байгаа гэдэгтээ биш шүү дээ. Асуусан асуулттай, та нарын хийсэн дүгнэлттэй холбоотой л асуулт асуухаар тийм юм үүсээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо үүнийгээ Ж.Бат-Эрдэнэ дарга аа, Эдийн засгийн байнгын хороон дарга аа, хоёр Байнгын хороо хуралдаж байгаа юм чинь нэг чиглэл гаргаад, тогтоол гаргаад үүнийг засаж запруулах юм хийхгүй бол энэ чинь өөрчлөгдөхгүй шүү дээ. Дараа нь яг энэ хэвээрээ л орж ирнэ.

Тэгэхээр чиглэлийн яам нь хяналт, дүгнэлт, үнэлгээгээ хийгээд, Их Хурлын Тамгын газар нь дүн шинжилгээ хийгээд, тэгээд аудит нь дүгнэлтээ гаргаад ийм хэлбэр рүү оруулахгүй бол болохгүй байна.

**Ж.Бат-Эрдэнэ:** М.Мандхай гишүүн.

**М.Мандхай:** Би нэг ойлгомжгүй байгаа юмаа бас энд Улсын Их Хурлын Тамгын газар энэ тэр сууж байгаа болохоор.

Гурван үнэлгээ яваад байгаа. Тийм ээ. Үндэсний аюулгүй байдал, дээрээс нь Засгийн газар, тэгээд Улсын Их Хурлын Тамгын газар гэсэн гурван үнэлгээ нь гурвуулаа яг альныг нь BENCHMARK болж ажиллах нь тодорхой биш байгаа байхгүй юу.

Тэгэхээр түрүүн Н.Учрал сайд хэлсэн. Ер нь төлөвлөгөө анхнаасаа асуудалтай байсан учраас ингээд үнэлгээ хүртэл ийм асуудал дагуулж байгаа юм. Гэхдээ хэрэв тийм бол нэг бол Улсын Их Хурлын Тамгын газрын үнэлгээг BENCHMARK болгож бариад, түүнтэй нь бид Засгийн газрын үнэлгээг харьцуулаад, түүн дээр нь бид асуулт хариултаа тавиад явмаар байгаа юм.

Үгүй бол Үндэсний аудитын газар. Үндэсний аудитын газар үнэхээр нарийн судалгаа, шинжилгээ хийгээд, дүн шинжилгээ гаргаад үнэлгээ гаргаж байгаа бол Үндэсний аудитын газрыг баримаар байна. Тэгэхгүй бол бид ингээд гурван үнэлгээн дунд яг альныг нь яг BENCHMARK болгож барих нь тодорхой бус байгаа юм. Энэ дээр анхаарч ажиллаач ээ. Эсвэл бид нарт сургалт ордог юу, зааварчилгаа өгдөг юу. Яг энэ дээр маш ойлгомжгүй байгаад байна.

Хоёрдугаарт, Хөдөө аж ахуйн яаманд би ийм асуудал яримаар байгаа юм. Тэргүүлэх чиглэлийн чинь хамгийн гол асуудал хүнсний аюулгүй байдал байгаа. Хүнсний аюулгүй байдлын энэ индекс тооцох аргачлал байхгүй учраас бид үндсэндээ энэ 5 дахь чиглэл буюу хүнсний хангамж аюулгүй байдлыг сайжруулах ажил маань үндсэндээ нурж байна гэсэн үг. Тийм ээ.

Тэгэхээр бодлогын яамны хувьд энэ индексээ гаргаач ээ. Эсвэл энэ индексийг бодлогын яаманд хийх тийм потенциал чадавх байхгүй гэж бодож байгаа бол холбогдох газар нь мэдээлээд үүнийг нэн яаралтай аргачлалаа гаргахгүй бол бид энд үнэлгээ хийгээд аргачлал нь байхгүй, индикатор нь тодорхой бус юмыг яриад суух угаасаа хайран цаг л байна л даа.

Тэгэхээр энэ дээр нэг анхаарч ажиллаад эргээд бид нарт хариу мэдээлэл өгөөч. Яг энэ аргачлал дээр яах ёстой юм. Хэрэв байгаа бол үүнийгээ тодорхой энэ дээр дараагийн удаа тусгамаар байна. Тэгэхгүй бол энэ дээр ямар ч.

Үндэсний энэ аудитын газар хэлсэн байна шүү дээ. Ямар ч индикатор байхгүй учраас энэ үндсэндээ тэргүүлэх чиглэл үйлчлэхгүй гэсэн дүгнэлт өгчихсөн байгаад байна. Энэ дээр Хөдөө аж ахуйн яам эргээд хариу өгөөрэй.

**Ж.Бат-Эрдэнэ:** Б.Пүрэвдорж гишүүн микрофонд үгээ хэльье.

**Б.Пүрэвдорж:** Энэ 7.1 дээр авлигалин үзүүлэлтийг сайжруулна, авлигалин гэмт хэргийг бууруулна, авлигатай тэмцэх үндэсний төлбөрийг хэрэгжүүлнэ гээд. Тэгээд тэр нь 100 хувь гээд тавьчихсан байгаа юм.

Тэгээд авлигат хаана байхгүй болчихсон юм. Монгол орныг энэ авлигат хэрэн сүлжчихсэн байгаа. Тэгээд үүнийгээ 100 хувьтай гээд оруулаад ирэхээр хүмүүс бухимдах нь аргагүй байхгүй юу даа.

Тэгэхээр ийм байдлаар одоо жишээ нь энэ гурван өөр дүгнэлт байгаа болохоор чинь энэ дээр нь тэгээд хамгийн сайнуудаа л ялгаад оруулчихсан байгаа шүү дээ. Муунууд тэртээ тэргүй энэ дүгнэлтэд ороогүй байгаа. Муу юмаа нуугаад үлдчихсэн л байгаа. Яамд бүгдээрээ.

Ийм байдлаар оруулж ирчхээд түүнийгээ бид нарыг дахиж сайн дүгнэ гэдэг ийм л юм яриад байгаа нь болохгүй байгаа байхгүй юу. Энэ дээр юу болохгүй байна вэ гэхээр энэ ерөөсөө засаглалын гол хүнд зориулсан,

намуудад зориулсан ийм яамдуудыг байгуулаад тэгээд 24 ч сайдтай билүү. Тийм ээ. 20 яамтай болгоод ингээд явчхаар чинь ерөөсөө ингээд нэг тийм ажил төрлөө булаацалдсан баахан хүмүүс. Энэ хүнд зориулсан яамдыг бий болгосноос болж л ийм л зүйл бий болж байгаа юм.

Тийм учраас энэ засаглалын хямралаа сайжруулах, зөв болгох, түүний үндсэн дээр хүнд суртал буурах, энэ бүх зүйлүүдийг хийх ёстой байхгүй юу даа. Тэгээд яг хамтарсан гэчхээд яг Монгол Ардын намынхан хэдэн гишүүдээрээ өнөөх л хамгийн их гал барьж байгаа, хамгийн их ажил хийж байгаа, хамгийн их зовлонтой тулж байгаа тэр Ардчилсан намын нөхдүүд рүү л дайруулдаг ийм л ажил хийгээд байгаа юм л даа.

Дээрээс нь энд сууж байгаа тэр төрийн албан хаагч нар нь буцаагаад Их Хурлын гишүүд рүү хариулж байгаа тэр зүйл нь ямар ч утгагүй.

Жишээ нь, Н.Тавинбэх сайд та 2020 оноос хойш сайд байсан. 2022 оноос Төрийн нарийн бичгийн дарга байсан. Хадаас чадаагүй 8 жил болж байгаа тэр компаниудыг бүгдийг нь цуцлах эрх танд бүгдэд нь байгаа шүү дээ. Танд энэ албан тушаал дээр чинь хоёулан дээр нь байсан шүү дээ. Тэгээд 7 жил хадаас хадаагүй гэж байна.

Тэгэхээр энэ чинь юу явж байна гэхээр үүний цаана авлигал явж байгаа байхгүй юу. Авлигал их хүчтэй явсан учраас амь бөхтэй өнөөдрийг хүртэл байж байгаа байхгүй юу даа. Тэр компаниуд. Тэр компаниуд авлигал өгсөн учраас та нарын толгой дээр гарчихсан байгаа байхгүй юу даа.

Гэтэл энэ 7.1 дээр чинь авлигал 100 хувиар бууруулаад ганган болчихсон гэж яриад байдаг. Ийм утгагүй зүйл ороод ирсэн учраас л би бухимдаад байгаа юм. Бусдаар жирийн албан хаагч нар энэ тэрд хамаа байхгүй л дээ.

Доогуураа нэг гараараа хамтарч явчхаад, нөгөө гараараа дандаа ийм хогийн юм хийдэг. Энэ хуучин коммунист нам. Яг л. Тэгээд л юу ч хийхгүй. Манай энэ Н.Учралаас бусад нь юу ч хийхгүй. Тэгээд нэг халамж, тэр нэг тараадаг бүх яам дээр нь очоод суучихдаг. Юу ч хийхгүй. Халуун гал атгахгүй.

Тэгээд ерөөсөө ийм байдлаар энэ засагт хамтарна гэх юм бол, одоо ийм байдлаар хүмүүст дээрэлхүүлээд явна гэх юм бол манай хэд засгаасаа гарсан нь дээр дээ.

**Ж.Бат-Эрдэнэ:** Гишүүд үг хэлж дууслаа. Тэгээд төгсгөл дээр нь өөрийнхөө нэг үгийг хэлчихдэг юм уу гээд.

Засгийн газрын 2024 оны гүйцэтгэлийг үзэж байгаа шүү дээ. Бид нар. Тэгээд нэгдүгээрт сайд нар байх хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, энэ олон төрийн албан хаагчдаа авчирдгаа ер нь болих хэрэгтэй байна. Н.Учрал сайд аа. Энэ дээр бас нэг анхаарахгүй бол. Нэгэнт бид Засгийн газарт ороод сайд дарга нараа хийгээд хариуцлага үүрнэ гэж байгаа бол энэ ажлаа судал л даа. Ажлаа мэддэг байх хэрэгтэй байна шүү дээ.

Тэгээд баахан хариулт араас нь өгдөг хэдэн нөхдүүд ингээд араасаа бүр. Ямар ч урт сүүлтэй юм. Баахан хүмүүс дагуулаад ороод ирдэг. Ажлыг нь хийлгэхгүй. Бүтэн байгууллага тэр чигээрээ ирж байна шүү дээ. Үүнийг болих хэрэгтэй байна шүү дээ. Сайд нь Төрийн нарийн бичгийн даргатай, газрын хоёр даргатайгаа гол гол бодлогын чиглэлийн асуудлаа хариуцдаг ийм дарга нар байхад бүгдийг нь хариулаад явчихна шүү дээ. Явчихдаг шүү дээ. Ер нь бол.

Тэгээд өөрсдөө ажил мэдэхгүй байгаагийн л шинж шүү дээ. Тэр олон хүн дагуулж орж ирнэ гэдэг чинь.

Хоёрдугаарт, сайд нар нэлээн хариуцлагатай байх хэрэгтэй байна. Бид чинь одоо энэ хамтарсан засаг гээд бие бие рүүгээ нялаад, тэрний, миний, чиний гээд байх юм байхгүй шүү дээ. Энэ чинь нэг л Засгийн газар. Нэг л бодлоготой, нэг л хөтөлбөртэй, нэг л хөтөлбөр хэрэгжүүлэхийн төлөө л явж байгаа. Тэр янз янзын баас цэвэрлэж байна гэсэн асуудлууд байхгүй. Баас цэвэрлэхээр байгаа бол тэрийгээ цэвэрлээд тодорхой хариултаа өг л дөө. Тэгвэл. Ийм баас байсныг нь ингэж ингэж цэвэрлэлээ гэдгийг нь хэлэх хэрэгтэй байна шүү дээ. Тэгэхгүй тэгээд асуулт хариулт бол дандаа буцаад бухсан, тайлбар хийсэн ийм л хариултууд яваад байна.

Одоо маргааш нөгөөдрөөс чуулганы хуралдаанд ороод нэлээн асуултууд орж ирэх байх. Хэлэлцэнэ шүү дээ. Тэгээд түүн дээр энэ сайд нар өөрсдөө хариултуудаа бэлдээд орж ирэх шаардлагатай байна.

Тэр үнэлгээний асуудал дээр гишүүдийн яриад байгаа зөв шүү. Үнэлгээ чинь тодорхой бус болохоор энд тодорхой хариулт нь гарч ирэхгүй. Үнэлгээ чинь буруу яваад байх шиг байна. Хоёр, гурван янз янзын үнэлгээнүүд яваад байх шиг байна.

Дээрээс нь аудитын үнэлгээ маш чухал. Аудитын үнэлгээ маш чухал шүү дээ.

Тийм болохоор энэ үнэлгээнүүдээ нэгтгэх тал дээр Хэрэг эрхлэх газар тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна. Гишүүдийн хэлээд байгаа асуудал чинь ерөөсөө энэ шүү дээ. Тэгээд нэгдэх ёстой юм уу, үнэлгээ нэг байх ёстой юм уу. Ойлгомжтой байх. Шаардлагатай бол тэр үнэлгээ гаргаж байгаа үнэлгээний журам, эсвэл хууль, тэр бүх зүйлд нь шинэчлэл оруулах хэрэгтэй байна шүү дээ.

Одоо дараа дараагийн 2025 оных орж ирнэ. 2026. Тэгээд ингээд жил жилийнхтэй дахиад нэг ийм юмнуудаа яриад суугаад баймааргүй байна шүү дээ.

Тийм болохоор үнэхээр бодитойгоор энэ ажил хийж л байгаа бол үнэхээр. Ажил хийгээгүй гэж хэлээгүй шүү дээ. Ажил хийж байгаа, зүтгэж л байгаа. Мэдээж Засгийн газар тодорхой хуралдааныхаа үндсэн дээр том том асуудлуудыг шийдээд явж байгаа.

Тийм болохоор энэ дээрээ анхаараад цааш цаашдаа энэ гишүүдийн хэлж байгаа зүйлдээ нэлээн дүн шинжилгээ хийж яваарай гэдгийг хэлэх хэрэгтэй байна.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэл болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Монгол Улсыг 2024-өөс 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай гишүүн танилцуулах уу? М.Мандхай гишүүн танилцуулъя.

Ингээд Байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооныхонд баярлалаа. /алх цохив/

Хамтарсан хуралдаан 2 цаг 21 минут үргэлжилж, 15 цаг 52 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**